



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 12 сарын 26-ны
сүрийн 1578 дугаарт бүртгэв.

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/554

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагыг магадлан
шинжлэх шалгуур батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.4, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуурыг нэгдүгээр, Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагад магадлан шинжлэх шалгуураар үнэлгээ хийх аргачлалыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллага, магадлан итгэмжлэлийн шинжээчдийг магадлан шинжлэх шалгуураар үнэлгээ хийх арга зүйгээр ханган, сургалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллага, шинжээчдэд хийх сургалтын зардлыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 07 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

1110270972 9087443


САЙД

(Handwritten signature and official stamp)

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
07 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд
МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулоор өлгөсөн ажилтны гарын үсэг
D. Зүе
2019 оны 12 сарын 25 өдөр

Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
 12 дугаар сарын 06-ны өдрийн
 А/557 дугаар тушаалын нэгдүгээр
 хавсралт



**ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ
 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР**

БҮЛЭГ 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэд бүлэг 1. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ
1.	Байгууллага нь тусламж, үйлчилгээ үзүүлэх бүрт үйлчлүүлэгчээ зөв таньж, үйлчилгээ үзүүлдэг тогтолцоо бүрдүүлсэн байна.	1.1. Байгууллага нь үзлэг, оношилгоо, эмчилгээ, ажилбар, үйлдэл хийхийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таних үйл явцыг тодорхойлж, баталгаажуулсан байх	1. Мэс засал, мэс ажилбар, эм өгөх, тарилга хийх, шинжилгээ авах, цус, цусан бүтээгдэхүүн /ЦЦБ/ сэлбэх, тусгай эмчилгээний хоол хүргэх зэрэг үйлдэл хийх бүрийн өмнө үйлчлүүлэгчийг таньж тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл явцыг тодорхойлсон журам баталсан 2. Үйлчлүүлэгчийг зөв таньж тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл явцыг тодорхойлсон журмыг нийт ажилтнуудад танилцуулсан, мөрддөг 3. Хэрэгжилтэд тогтмол хяналт тавьдаг	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
		1.2. Байгууллага нь үйлчлүүлэгчийг зөв таних аргыг тодорхойлсон, хэрэглэдэг байх	1. Үйлчлүүлэгчийг зөв таних 2-оос доошгүй аргыг байгууллагын хэмжээнд /өрөөний дугаар, байрлалыг оруулахгүй/ баталгаажуулсан, хэрэглэж хэвшсэн 2. Үйлчлүүлэгчийг зөв таних аргыг ашиглах талаар эрүүл мэндийн ажилтнуудад заавар өгдөг	5, 4, 3, 2, 0
		1.3. Ямар нэг ажилбар, үйлдэл хийхийн өмнө үйлчлүүлэгчийг таньдаг байх	1. Үзлэг, оношилгоо, эмчилгээний ажилбар /мэс засал, мэс ажилбар, эм өгөх, тарилга хийх, шинжилгээ авах, ЦЦБ сэлбэх, тусгай хоол хүргэх зэрэг/, үйлдэл хийх бүрийн өмнө үйлчлүүлэгчийг таних аргыг ашигладаг 2. Баримт бичгийн тэмдэглэгээ, хяналтын хуудас хөтөлдөг 3. Үйлчлүүлэгчийг зөв таних үйл явцыг хянадаг	5, 4, 3, 2, 0
		1.4. Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг зөв таньж тусламж,	1. Нярай, ухаангүй, сэтгэцийн эмгэгтэй өвчтөн зэрэг харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг таних үйл явц,	5, 4, 3, 2, 0

		үйлчилгээ үзүүлдэг байх	аргыг тодорхойлсон, хэрэгжүүлдэг 3. Хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг таних талаар журамд тусгасан, хэрэгжүүлдэг 4. Баримт бичгийн тэмдэглэгээ, хяналтын хуудас хөтөлдөг 5. Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчийг зөв таних үйл явцыг хянадаг	
2.	Байгууллага нь үйлчлүүлэгчтэй харилцах, холбоо тогтоох, мэдээлэл өгөх тогтолцоог бүрдүүлсэн байна.	2.1.Үйлчлүүлэгчээс амаар, утсаар мэдээлэл авах, мэдээлэл өгөх үйл явцыг тодорхойлж, баталгаажуулсан байх	1. Үйлчлүүлэгчээс аман болон утсаар мэдээлэл /захиалга авах/ авах, өгөх журамтай, баталгаажуулсан 2. Үйлчлүүлэгчээс аман болон утсаар авсан мэдээлэл авах, өгөх журам нийт ажилтнуудад танилцуулсан	5, 4, 3, 2, 0
		2.2.Үйлчлүүлэгчээс аман болон утсаар мэдээлэл авах, мэдээлэл өгөх журмыг мөрддөг байх	1. Үйлчлүүлэгчийн амаар болон утсаар өгсөн мэдээллийг давтан хэлж, баталгаажуулан тэмдэглэдэг 2. Эмнэлгийн ажилтны үйлчлүүлэгчид утсаар болон амаар мэдээлэл өгч, авч буй үйл явцад хяналт тавьдаг, зөвлөгөө өгдөг	5, 4, 3, 2, 0
		2.3.Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчээс мэдээлэл авах, мэдээлэл өгөх үйл явцыг тодорхойлж, баталгаажуулсан байх	1. Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах үйлчилгээг зохицуулсан журамтай 2. Ажилтан бэлтгэж, сургасан 3. Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах аргыг ашигладаг 4. Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж байгаа үйл явцад хяналт тавьдаг	5, 4, 3, 2, 0
3.	Үйлчлүүлэгчийн оношилгоо, шинжилгээний дүгнэлтийг бүртгэх, мэдээллэх тогтолцоотой байна.	3.1.Өвчтөнд хийгдсэн яаралтай шинжилгээний, шинжилгээний аюултай /анхаарал татсан/ хариуг бүртгэх мэдээлэх, мэдээллийг баталгаажуулах үйл явцыг тодорхойлсон, мөрддөг байх	1. Яаралтай шинжилгээ болон шинжилгээний аюултай /анхаарал татсан/ хариуг бүртгэх, мэдээллэх, мэдээллийг баталгаажуулах үйл явцыг тодорхойлсон журам, зураглалтай, баталгаажуулсан 2. Яаралтай шинжилгээ болон шинжилгээний аюултай /анхаарал татсан/ хариуг амаар болон утсаар мэдээлсэн тухай тэмдэглэл хөтөлж, баталгаажуулдаг 3. Амаар хэлсэн шинжилгээний үр дүнг хүлээн авагч бүрэн тэмдэглэн авч, буцаан унших, заавар өгөгч эргүүлэн уншиж дахин баталгаажуулж хэвшсэн	5, 4, 3, 2, 0
		3.2.Лабораторийн болон үйл онош /дүрс оношилгоо/-ийн шинжилгээний хариуны аюултай хариуг мэдээлэх үйл явцыг тодорхойлж, баталгаажуулсан, мөрддөг байх	1. Лабораторийн болон үйл онош /дүрс оношилгоо/-ийн шинжилгээний хариуны аюултай өгөгдлийг тодорхойлсон 2. Лабораторийн болон үйл онош /дүрс оношилгоо/-ийн шинжилгээний аюултай хариуг мэдээлэх үйл явцын зураглал /Хэн, ямар албан тушаалтанд, ямар хугацаанд мэдээлэх/-ыг гаргаж, баталгаажуулсан 3. Шинжилгээний аюултай хариуг бүртгэж, баримтжуулсан 4. Лабораторийн болон үйл онош /дүрс оношилгоо/-ийн	5, 4, 3, 2, 0

			шинжилгээний аюултай хариуг мэдээлсэн тэмдэглэл	
		3.3.Үйлчлүүлэгчийн шинжилгээний хариуг бүртгэж, баримтжуулсан байх	1. Үйлчлүүлэгчийн шинжилгээний хариуг бүртгэж, баримтжуулдаг 2. Шинжилгээний хариуг баримтжуулсан бүртгэлд хяналт тавьдаг	5, 4, 3, 2, 0
4.	Үйлчлүүлэгчийн эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой баримт бичгийг хөтлөх зохицуулалтыг хийсэн байна.	4.1.Өвчтөний түүх, баримт бичгийн гар бичлэг, товчлол үг бичих, ашиглах тухай журамтай байх	1. Байгууллагын хэмжээнд оношилгоо, эмчилгээнд хөтлөгдөх баримт бичиг, гар бичлэг, товчлол үг бичих, ашиглах журамтай 2. Өвчтөний түүх болон бусад баримт бичгийн хөтлөлтөд хяналт тавьдаг	5, 4, 3, 2, 0
5.	Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг хангасан тогтолцоо бүрдүүлсэн байна.	5.1.Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эм /антикоагулянт, инсулин, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, хими эмчилгээний эм, тариа зэрэг/-ийн аюулгүй байдлыг хангадаг байх	1. Байгууллагын хэмжээнд өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийг тодорхойлж, тэдгээрийн хадгалалт, жор бичилт, бэлтгэн түгээх, хэрэглээ ба хяналтын асуудлыг тусгаж баталсан журамтай, хэрэгжүүлдэг 2. Эмийн сан болон тасаг, нэгжид өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авсан /эмийн жагсаалттай, хадгалалт, зарцуулалтын заавар, зөвлөгөө өгөх, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт хийх г.м/	5, 4, 3, 2, 0
		5.2.Өндөр эрсдэл үүсгэх болон ижил дуудагддаг, гадна байдал нь ижил харагддаг эмийн жагсаалттай байх	1. Өндөр эрсдэл үүсгэх, ижил дуудагддаг, гадна байдал нь ижил харагддаг эмийн жагсаалтыг гаргаж, баталгаажуулсан 2. Өндөр эрсдэл үүсгэх, ижил дуудагддаг, ижил харагддаг эмийн жагсаалт, үзүүлэн, самбарыг эмчилгээний бүх тасаг, нэгжид байршуулсан 3. Эмийн хадгалалт, түгээлт, зарцуулалтын бүртгэл болон бусад баримт бичгийг хөтөлдөг	5, 4, 3, 2, 0
		5.3.Өндөр эрсдэл үүсгэх эм, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн талаар эрүүл мэндийн ажилтнуудад заавар өгдөг байх	1. Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эм, ижил дуудагддаг, ижил харагддаг эмийн талаар эрүүл мэндийн ажилтнуудад тогтмол мэдээлэл, заавар өгдөг 2. Танилцуулга, гарын авлагатай, ашигладаг	5, 4, 3, 2, 0
		5.4. Тасаг, нэгжид өндөр эрсдэл үүсгэх, ижилдуудагддаг, ижил харагддаг эмүүдийн хэрэглээнд хяналт хийдэг байх	1. Ижил нэртэй, өөр тунтай эмийн нэршил, тун, савлагааг нарийвчлан шалгаж, хянадаг 2. Хийсэн хяналт, үнэлгээний тайлан, дүгнэлттэй 3. Авсан арга хэмжээ, гарсан үр дүнг тодорхойлсон	5, 4, 3, 2, 0
6.	Байгууллага нь буруу үйлчлүүлэгчид,	6.1. Мэс засал, мэс ажилбарын аюулгүй байдлыг хангах заавартай, мөрддөг байх	1. Мэс засал, мэс ажилбарын аюулгүй байдлыг хангах зааврыг баталсан, тасаг, нэгжид мөрдүүлэх зохион байгуулалтыг хийсэн	5, 4, 3, 2, 0

	<p>буруу талбайд, буруу мэс засал хийхээс сэргийлж, мэс заслын аюулгүй байдлыг хангасан байна.</p>		<p>2. Мэс засал, мэс ажилбар хийх өвчтөн бүрт дараах баримт бичгийг хөтлөхөөр баталгаажуулсан: а.Өвчний түүхэн дэх мэс заслын өмнөх үзлэг, дүгнэлт /мэс заслын болон мэдээгүйжүүлгийн эмч нарын/ б.Мэс заслын зөвшөөрлийн хуудас в.Мэс заслын өмнөх хяналтын хуудас г.Мэдээгүйжүүлгийн зөвшөөрлийн хуудас д.Цус цусан бүтээгдэхүүн хийх зөвшөөрлийн хуудас е.Зөв үйлчлүүлэгчид, зөв талбайд, зөв мэс засал төлөвлөгдсөн эсэх бусад баримт бичиг</p>	
		<p>6.2.Мэс засал, мэс ажилбар, үйлдлийн аюулгүй байдлыг хянадаг байх</p>	<p>1. Мэс засал, мэс ажилбар, үйлдлийн аюулгүй байдлыг тогтмол хянадаг 2. Хяналт, үнэлгээний мөрөөр арга хэмжээ авч ажилладаг 3. Гарсан үр дүнг дүгнэдэг</p>	
<p>7.</p>	<p>Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн байна.</p>	<p>7.1. Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг боловсруулж, баталсан байх</p>	<p>1. Өөрийн байгууллагын нөхцөлд тохируулан нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг боловсруулж, баталсан 2. Хөтөлбөр нь халдварын үеийн антибиотик эмчилгээний болон антибиотик урьдчилан сэргийлэлтийн удирдамж /заавар/-тай 3. Нянгийн эсрэг эмийн жагсаалт баталсан 4. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт хийдэг</p>	<p>5, 4, 3, 2, 0</p>
		<p>7.2.Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах тогтолцоог бүрдүүлсэн байх</p>	<p>1. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны дэргэд нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Антибиотикийн дэд хороо” ажиллуулдаг 2. “Антибиотикийн дэд хороо” нь Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг хангадаг 3. Тасгуудад хэрэглэж байгаа нянгийн эсрэг эмийн хэрэглээг үнэлдэг, нянгийн мэдрэг чанарыг судалж, үр дүнг эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулдаг 4. Эмнэлгийн орчинд “нутагшсан” нян ба антибиотик тэсвэрт чанарын судалгааг тогтмол хийдэг</p>	<p>5, 4, 3, 2, 0</p>
		<p>7.3 Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийн үр дүнг тооцдог байх</p>	<p>1. Антибитикийн хэрэглээний судалгаа хийдэг 2. Хийгдсэн ажиглалт судалгааны үндсэн дээр өөрийн байгууллагад баримтлах антибиотик эмчилгээний цаашдын чиглэлийг боловсруулахад санал гаргадаг 3. Антибиотикийн биохүрэхүйн судалгааны дүн, мэдрэг</p>	<p>5, 4, 3, 2, 0</p>

			чанарын шинжилгээг тогтмол хийдэг 4. Антибиотик хэрэглээний чанарын үзүүлэлтийг баталж, чанарын үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийдэг	
8.	Эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч унаж, гэмтэхээс сэргийлэх арга хэмжээ авдаг байна.	8.1. Байгууллага, тасаг, нэгжийн гадаад, дотоод орчинд үйлчлүүлэгч унаж, гэмтэх эрсдлээс сэргийлдэг байх	1. Байгууллага, тасаг, нэгжийн орчиндүйлчлүүлэгч унаж, гэмтэхээс сэргийлэх чиглэлээр баталсан журамтай 2. Байгууллагын гадаад, дотоод орчинд тогтмол үнэлгээ хийж, эрсдлийг тогтоодог 3. Байгууллагын гадаад орчинд үйлчлүүлэгч явганаас унаж, гэмтэх эрсдэл үүсэхээс сэргийлэх арга хэмжээ, тогтмол авдаг /зам талбайн бүрэн бүтэн байдал, хальтиргаа, гулгаа үүсэх, шатны хонгил, орох хаалганы орчин, шалны материал, бариул гэх мэт/ 4. Тасаг, нэгж бүрийн дотоод орчинд үйлчлүүлэгч унах эрсдэлтэй нөхцөл байдал болон байршлыг тодорхойлж, сэргийлэх арга хэмжээ авдаг/шатны хонгил, коридорууд, хаалга, шалны материал, бариул гэх мэт/ 5. Үйлчлүүлэгчийг унах эрсдлээс сэргийлсэн анхааруулга, таних тэмдэг, тэмдэглэгээ хийсэн 6. Анхааруулга, таних тэмдэг, тэмдэглэгээ нь үйлчлүүлэгчид ойлгомжтой, энгийн, үзэмжтэй	5, 4, 3, 2, 0
		8.2. Үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ хийж, унах эрсдэлийг тодорхойлж, гэмтэж бэртэхээс сэргийлдэг байх	1. Үйлчлүүлэгчийн биеийн байдал, онош болон бусад нөхцөл байдалд үндэслэн унаж гэмтэх эрсдэлийг үнэлдэг шалгуур үзүүлэлтийг баталсан /Таталт өгдөг эсэх, эмийн хэрэглээ, архины хэрэглээ, алхахад асуудалтай эсэх, тэнцвэрийн байдал зэрэг/ 2. Үйлчлүүлэгчийн онцлогт тохирсон, унахаас хамгаалдаг шаардлагатай хэрэгслээр хангаж, ашигладаг /тэргэнцэр, бугуйн зүүлт болон бусад/ 3. Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчийг байгууллагын бүх ажилтнууд таньж мэддэг, сэргийлэх арга хэмжээ авч, тусламж үзүүлдэг 4. Үнэлгээ болон унахаас сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээг баримтжуулсан	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	
		Авсан оноо	

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР**

БҮЛЭГ 1.ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэд бүлэг 2. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ
1.	Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хянах тогтолцоог бүрдүүлсэн байна.	<p>1.1. Байгууллага нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байх</p> <p>1.2.Амбулатори, хүлээн авах, хэвтүүлэн эмчлэх тасаг, нэгжийн зохион байгуулалтыг үйл ажиллагаа, үйлчилгээний ачаалал, эрэлт хэрэгцээ, үйлчлүүлэгчийн урсгал, хөдөлгөөнтэй уялдуулан хийсэн байх</p> <p>1.3.Хэвтүүлэн эмчлүүлэгчийн орны хүлээгдэлд тогтмол дүн шинжилгээ хийж, арга хэмжээ авдаг байх</p>	<p>1. Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг зохицуулсан журамтай</p> <p>2. Журмын хэрэгжилтийг хангаж, ажилладаг</p> <p>3. Хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлдэг</p> <p>1. Амбулатори, хүлээн авах, хэвтүүлэн эмчлэх тасаг, нэгжийн үйл ажиллагаа, үйлчилгээний ачаалал, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээ, урсгал хөдөлгөөнд тогтмол дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгдөг</p> <p>2. Дүн шинжилгээ хийсэн тайлантай/7 хоног, сар, улирлаар/</p> <p>3. Үйлчлүүлэгчийн урсгал, хөдөлгөөн, ачаалалд хийсэн дүгнэлтийг үндэслэн зохион байгуулалтын арга хэмжээ авдаг</p> <p>1. Орны ачаалал, хүлээгдэлд тогтмол дүгнэлт өгдөг</p> <p>2. Хэвтүүлэн эмчлүүлэгчдийн бүртгэл, судалгаатай</p> <p>3. Хүлээгдлийг зохицуулах, бууруулах арга хэмжээ авдаг</p>	<p>Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.</p> <p>5, 4, 3, 2, 0</p> <p>5, 4, 3, 2, 0</p>
2.	Тусламж, үйлчилгээг тасралтгүй авах мэдээллээр үйлчлүүлэгчийг хангасан байна.	2.1.Байгууллага нь үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, зохицуулалт, ачаалал, хүлээгдлийн талаар мэдээллийн самбар, цахим хуудсанд тогтмол мэдээлдэг байх	<p>1. Байгууллагын үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, цагийн хуваарь, ачаалал, хүлээгдлийн талаарх мэдээллийг үйлчлүүлэгч авах нөхцөлийг бүрдүүлсэн, тогтмол мэдээлдэг</p> <p>2. Самбар /цахим дэлгэц/, цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй</p> <p>3. Тусламж, үйлчилгээний болон мэдээллийн ил тод байдлыг хангасан</p>	5, 4, 3, 2, 0

3.	Үйлчлүүлэгчийг хүлээн авах, тусламж, үйлчилгээ үзүүлэх, шилжүүлэх, хүлээлцэх, эмнэлгээс гаргах үйл ажиллагааг зохицуулсан байна.	3.1. Үйлчлүүлэгчийг хүлээн авах журамтай, түүний зохицуулалтад хяналт тавьдаг байх	1. Үйлчлүүлэгчийг хүлээн авах баталсан журамтай 2. Бүртгэл, мэдээ, тайлан, дүгнэлттэй ажилладаг 3. Хяналт тавьсан, зохицуулалт хийж, авсан арга хэмжээний үр дүнг тооцсон	5, 4, 3, 2, 0
		3.2.Тусламж, үйлчилгээний стандарт, удирдамж, зааварт үндэслэн үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчлэх шалгуурыг баталсан, мөрддөг байх	1. Оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, зааварт үндэслэн тасаг/нэгж бүрт хэвтүүлэн эмчлэх шалгуур, өвчин эмгэгийн баталсан жагсаалттай, мөрддөг 2. Шалгуурын дагуу хэвтүүлдэг, бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0
		3.3.Үйлчлүүлэгчийг шилжүүлэх, хүлээлцэх журамтай, түүний хэрэгжилтэд хяналт тавьдаг байх	1. Үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн байгууллага хооронд, тасаг хооронд шилжүүлэх, хүлээлцэх журамтай, баталгаажуулсан 2. Үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн байгууллага хооронд, тасаг хооронд шилжүүлэхэд биечлэн хүлээлцэж, мэдээлэл солилцдог 1. Өвчтөн шилжүүлэх, хүлээлцэхжурмыг нийт ажилтнуудад танилцуулсан, мөрдөлтөд хяналт тавьдаг	5, 4, 3, 2, 0
		3.4.Шилжүүлсэнүйлчлүүлэгчээ бүртгэж, эргэжхянаж, дүгнэлт өгч ажилладаг байх	1. Шилжүүлсэн үйлчлүүлэгчийн биеийн байдалд хийсэн үнэлгээ, оношилгоо, шинжилгээ, эмчилгээний талаарх мэдээллийг баримт бичигт тэмдэглэж, хүлээлгэн өгдөг 2. Шилжүүлсэн өвчтөний бүртгэл, мэдээлэлтэй	5, 4, 3, 2, 0
		3.5.Эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж авахаар илгээсэн үйлчлүүлэгчийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах арга хэмжээг авдаг байх	1. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ авахаар ирүүлсэн байгууллагатай хамтран өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах арга хэмжээг тухай бүр авч, зохицуулалт хийх журамтай, хэрэгжүүлдэг 1. Иргэнд товлосон хугацаанд тусламж, үйлчилгээ үзүүлсэн 2. Тусламж, үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчийн бүртгэлтэй /цахим бүртгэлийн маягт/ 3. Үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээ, үргэлжлүүлэн үзүүлэх тусламж, үйлчилгээ, өгсөн зөвлөгөөг баримт бичигт тэмдэглэн, илгээсэн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлдэг	5, 4, 3, 2, 0
		3.6.Тусламж, үйлчилгээ авахаар ирсэн тохиолдол бүрт бүртгэл хөтөлж, авсан арга хэмжээний талаар тэмдэглэл хөтөлдөг байх	1. Хүлээн авах, яаралтай тусламжийн тасагт тусламж авахаар ирсэн үйлчлүүлэгч бүрийг бүртгэдэг 2. Үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийх бүртхолбогдох анхан шатны бүртгэлийн маягт,	5, 4, 3, 2, 0

			<p>хяналтын хуудсыг хөтөлдөг</p> <p>3. Үйлчлүүлэгчийг буцаасан тохиолдолд өгсөн зөвлөгөө, үзүүлсэн тусламж, үйлчилгээний талаар тэмдэглэл хөтөлдөг</p>	
		3.7.Үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарахад заавар, зөвлөмж өгч, цаашид баримтлах дэглэм, үргэлжлүүлэн авах тусламж, үйлчилгээний талаар зөвлөдөг байх	<p>1. Үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарахад эмчлэгч эмч биечлэн заавар, зөвлөмж өгч, гарах үеийн дүгнэлтийг үйлчлүүлэгчийн амбулаторийн картанд тэмдэглэдэг</p> <p>2. Үйлчлүүлэгчийн амбулаторийн картанд цаашид баримтлах дэглэм, үргэлжлүүлэн авах эмчилгээ, үйлчилгээний талаар өгсөн зөвлөгөөг тэмдэглэсэн</p>	5, 4, 3, 2, 0
		3.8.Үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэх бүрт холбогдох баримт бичгийг хөтөлдөг байх	<p>1. Үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийх бүрт холбогдох анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлдөг</p> <p>2. Хяналтын хуудсыг хөтөлдөг</p> <p>3. Анхан шатны бүртгэлийн маягтын хөтлөлтөнд хяналт тавьдаг</p>	5, 4, 3, 2, 0
		3.9.Өвчний түүхийн хөтлөлт бүрэн байх	<p>1. Өвчний түүхийг стандартын дагуу хөтөлдөг</p> <p>2. Эмчийн үзлэг, эмчилгээ эхлэх, хийх цагийг өвчний түүхэнд бичсэн, эмчилгээг хугацаанд нь хийсэн</p> <p>3. Өвчний түүхийн бичилтэд хяналт тавьдаг</p>	5, 4, 3, 2, 0
4.	Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.	4.1.Үйлчлэх хүрээний болон бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилладаг байх	<p>1. Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах ажлын баталсан төлөвлөгөө, тайлантай</p> <p>2. Оношилгоо, эмчилгээнд зөвлөгөө өгсөн байгууллага, үйлчлүүлэгчийн бүртгэлтэй</p> <p>3. Ажлын байрны болон цахим сургалт хийсэн удирдамж, хөтөлбөртэй</p> <p>4. Ажлын байрны болон цахим сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдийн бүртгэлтэй</p> <p>5. Боловсруулж хэвлүүлсэн ном, гарын авлагатай, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн</p>	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	
		Авсан оноо	

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР**

БҮЛЭГ 1.ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэд бүлэг 3. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ
1.	Үйлчлүүлэгчийг мэдээллээр хангаж, лавлагаа, мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг байна.	1.1.Лавлагаа мэдээллийн хөтөч/ажилтан, лавлагаа өгөх цэг ажиллуулдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Лавлагаа мэдээллийн хөтөч, мэдээлэл өгөх үйлчилгээний цэгүүдийг зохион байгуулсан, ажиллах батлагдсан журамтай 2. Лавлагаа мэдээллийн хөтөч/ажилтанг сургасан 3. Үйлчлүүлэгч мэдээлэл авах булан, самбар ажиллуулдаг /цахим дэлгэц, самбар/ 4. Лавлагаа мэдээллийн цэгт байгууллага, тасаг, нэгжийн үйл ажиллагаа, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээ, үйлчилгээний багц, төлбөрийн мэдээллийг ил тод байршуулсан 5. Байгууллагын зохион байгуулалт, үйлчилгээний чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтойгоор хийсэн 6. Хүлээлгийн танхимуудад мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийдэг 7. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны зурагт хуудас, гарын авлага, материалыг байршуулсан 	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
		1.2.Байгууллага нь үйлчлүүлэгчид тав тухтай орчин бүрдүүлж, үйлчилгээ үзүүлдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгч тав тухтай орчинд үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоод тохижилт хийгдсэн 2. Хүлээлгийн танхимууд нь тав тухтай, мэдээлэл авах боломжтой 3. Үйлчилгээ авахад саад бэрхшээлгүй 4. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч, хүүхэд, өндөр настан үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлсэн /ширээ, сандал, тэргэнцэр, хүүхдийн өрөө, ариун цэврийн өрөө гэх мэт/ 	5, 4, 3, 2, 0

		1.3.Товлолт үйлчилгээ үзүүлдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Утсаар болон цахимаар үзлэг, оношилгооны захиалгыг хүлээж авдаг 2. Үйлчлүүлэгчийн дараалал, цаг товлолыг цахим болон автомат бүртгэлээр зохицуулдаг 3. Цаг товллол, захиалгатай холбоотой асуудал гарсан тохиолдолд үйлчлүүлэгчид эргэн мэдээлж, тэмдэглэдэг 	5, 4, 3, 2, 0
2.	Байгууллага нь тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөн болон тэдний гэр бүлийн эрх ашгийг хамгаалах үүрэг, хариуцлагатай ажиллана.	2.1.Үйлчлүүлэгчийн эрх, үүргийг тодорхойлж, баталгаажуулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгчийн эрх, үүргийг баталгаажуулж, хүлээлгийн танхимуудад ил тод байршуулсан 2. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн ёс зүйнхэм хэмжээний талаар мэдээлдэг 3. Үйлчлүүлэгчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажил хийдэг 	5, 4, 3, 2, 0
		2.2.Үйлчилгээ үзүүлэгчийг үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, ёс зүйн хэмжээ хэмжээг мөрдүүлэх чиглэлээр сургасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Бүх ажилтнууд үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, ёс зүйн хэм хэмжээний талаар мэдлэгтэй, үйлчлүүлэгчид тайлбарлаж чаддаг 2. Үйлчлүүлэгчид зөвлөгөөгөөгөх, харилцааныурчадвартэмнэлгийнмэргэжилтэнгсургасан 3. Энэ чиглэлээр сургалтын удирдамж, хөтөлбөртэй, тасралтгүй сургалтыг зохион байгуулсан 4. Эмнэлгийнмэргэжилтний үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа, зөвлөгөөгөөгөх чадварт үнэлгээ хийдэг 	5, 4, 3, 2, 0
		2.3.Үйлчлүүлэгч тусламж, үйлчилгээний явцад биеийн, хэл ярианы, соёлын болон бусад саад бэрхшээл, чирэгдэлгүй үйлчилгээ авах нөхцөлийг хангасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Тусламж, үйлчилгээний явцад үйлчлүүлэгчид тулгарч болох биемахбодын, соёлын, хэл ярианы болон бусад саад бэрхшээлийг тодорхойлж, шийдвэрлэх арга хэмжээ авдаг 2. Үйлчлүүлэгчид тулгарч болох биемахбодын, соёлын, хэл ярианы болон бусад саад бэрхшээлийг шийдвэрлэх талаар ажилтныг сургасан 3. Үйлчлүүлэгчийн хувийн эд зүйлсийг хамгаалах чиглэлээр байгууллагын үүрэг, хариуцлагын талаарх мэдээлэл өгдөг 4. Үйлчлүүлэгчийн эд зүйлс алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авсан 	5, 4, 3, 2, 0

3.	Үйлчлүүлэгчийн эрхийг хүндэтгэж, тусламж, үйлчилгээний шийдвэр гаргалтад оролцуулдаг тогтолцоог бүрдүүлсэн байна.	3.1.Тусламж, үйлчилгээний шийдвэр гаргалтад үйлчлүүлэгчийг оролцуулдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгчид хийгдэх оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, түүний үр дүн, гарч болох эрсдлийн талаар өөрт нь болон гэр бүлийнхэнд нь энгийн үгээр, ойлгомжтой тайлбарлан танилцуулдаг 2. Үйлчлүүлэгчид хийгдэх оношилгоо, шинжилгээ, эмчилгээний талаар санал солилцож, тэдний шийдвэрийг сонсож хүндэтгэдэг 3. Үйлчлүүлэгчид хийгдэх оношилгоо, эмчилгээ, мэс заслын үр дүн, гарч болох хүндрэл, эрсдлийн талаар өөрт нь болон гэр бүлийнхэнд нь танилцуулж зөвшөөрөл авдаг 	5, 4, 3, 2, 0
		3.2.Байгууллага нь үйлчлүүлэгчийн биеийн байдал, оношилгоо, шинжилгээ, эмчилгээтэй холбоотой мэдээллийг үнэн, зөв өгдөг байх	<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгчийн биеийн байдал, оношилгоо, шинжилгээ, эмчилгээтэй холбоотой мэдээллийг өөрт нь болон тэдний гэр бүлийнхэнд өгөх баталсан журамтай, хэрэгжүүлдэг 2. Үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлийнхэнд биеийн байдал, оношилгоо, шинжилгээ, эмчилгээтэй холбоотой мэдээллийг хэн, хэзээ өгөх үйл явцыг тодорхойлсон 3. Үйлчлүүлэгч болон гэр бүлийнхэнд үнэн, зөв дараах мэдээллийг өгдөг: <ul style="list-style-type: none"> • оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийж байгаа эмнэлгийн мэргэжилтний нэр, ажлын туршлага • үйлчлүүлэгчийн биеийн байдал • эмчилгээ, мэс засал, ажилбар, үйлдлийн явц, үр дүн • гарч болох хүндрэл гэх мэт. 3. Үйлчлүүлэгчийн гэр бүлийнхэнтэй уулзах, мэдээлэл, зөвлөгөө өгөх өрөөтэй, тав тухтай байдлыг хангасан 	5, 4, 3, 2, 0
4.	Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг байна.	4.1.Байгууллагын болон тасаг, нэгжийн удирдлагууд үйлчлүүлэгч болон ажилтантай уулзаж, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын дарга болон удирдах ажилтнуудын тасаг, нэгжид ажиллах баталсан хуваарьтай, хуваарийн дагуу ажилладаг 2. Байгууллагын дарга болон удирдах ажилтнуудын тасаг, нэгжид ажилласан тухай тэмдэглэл хөтөлдөг 3. Үйлчлүүлэгчийн санал, хүсэлтийг хүлээн авах, уулзах баталсан хуваарьтай, хуваарийн дагуу ажилласан баримттай 4. Ажилтнуудыг хүлээн авч уулзах хуваарьтай, ажилласан баримттай 	5, 4, 3, 2, 0

		<p>5. Удирдлагын тасаг, нэгжид ажилласан, үйлчлүүлэгч, ажилтнуудтай уулзаж, шийдвэрлэсэн асуудал, авсан арга хэмжээний тайлан, үр дүн</p> <p>6. Шийдвэрлэх асуудлын тоо, шийдвэрлэсэн асуудлын тоо/хувь</p>	
	4.2. Байгууллага нь иргэний өргөдөл, гомдлыг судлан, эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг хийдэг байх	<p>1. Иргэний өргөдөл, гомдлыг судлан, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг холбогдох дүрэм, журмын дагуу хийдэг</p> <p>2. Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо/хувь</p> <p>3. Үйл ажиллагааны тайлан</p>	5, 4, 3, 2, 0
	4.3. Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг боломжит сувгаар хүлээн авч, тухай бүр бүрэн шийдвэрлэдэг, эргэн мэдээллэх тогтолцоотой байх	<p>1. Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг цахим, утсаар, амаар болон бичгээр авдаг</p> <p>2. Хариуцсан ажилтантай</p> <p>3. Ирсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлын бүртгэлийг хөтөлдөг</p> <p>4. Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийдэг</p> <p>5. Хугацаанд нь шийдвэрлэж, хариу өгч, эргэн мэдээлсэн өргөдлийн тоо/хувь</p>	5, 4, 3, 2, 0
	4.4. Үйлчлүүлэгч үзлэг, оношилгоо, эмчилгээний үр дүнд сэтгэл ханамжтай байх	<p>1. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүн</p> <p>2. Үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлагын дүгнэлт</p>	5, 4, 3, 2, 0
	4.5. Албан бус төлбөр, бэлэг авах, өгөх нөхцөлийг бүрдүүлэхгүй байх	<p>1. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүн</p> <p>2. Байгууллагын дотоод журамд албан бус төлбөр, бэлэг авах, өгөхийг хориглосон эсэх</p> <p>3. Дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавьдаг</p> <p>4. Албан бус төлбөр, бэлэг авах, өгөхийг хориглосон мэдээллийг ил тод байршуулсан</p> <p>5. Үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлагын дүгнэлт</p>	5, 4, 3, 2, 0
	4.6. Байгууллага нь үзүүлж буй тусламж, үйлчилгээ, авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар олон нийтэд сурталчилдаг тогтолцоотой байх	<p>1. Цахим хуудас болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал</p> <p>2. Байгууллагын хэмжээнд зохион байгуулсан ажлын тайлантай</p>	5, 4, 3, 2, 0
	4.7. Зорилтот бүлгийн иргэдийн тусгай хэрэгцээ, шаардлагыг хангасан орчинг бүрдүүлж, тусламж, үйлчилгээ үзүүлдэг	<p>1. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүн</p> <p>2. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд /харилцааны бэрхшээлтэй иргэд/ тусламж, үйлчилгээ авах орчныг бүрдүүлсэн</p>	5, 4, 3, 2, 0

		байх	3. Орон гэргүй, ядуу иргэд, хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ авахад нь дэмжлэг үзүүлдэг 4. Тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний бүртгэлтэй	
		4.8.Үйлчлүүлэгч, түүний гэр бүлийнхэн болон эмнэлгийн мэргэжилтэн эвлэрүүлэн зуучлах, хуульзүйн болон нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө авах нөхцлийг бүрдүүлсэн байх	1. Үйлчлүүлэгчид хууль эрх зүйн болон нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг 2. Мэргэжлийнсэтгэлзүйч, нийгмийнажилтан ажиллуулдаг 3. Нийгэм-сэтгэлзүйн болон хууль эрх зүйнзөвлөгөөөгсөн үйлчлүүлэгчийн бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0
		4.9.Үйлчлүүлэгчээс гарсан оношилгоо, эмчилгээний зардлын нөхөн төлбөрийг олгодог байх	1. Зайлшгүй шаардлагаар гаднаас эм, тариа авахуулсан, үйлчлүүлэгч оношилгоо, эмчилгээний төлбөрөө төлсөн тохиолдолд нөхөн төлбөрийг эргэн олгох талаар баталсан журамтай, мөрддөг 2. Нөхөн төлбөртэй холбоотой үйлчлүүлэгчийн гомдлын шийдвэрлэлт 3. Нөхөн төлбөр олгосон үйлчлүүлэгчийн бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0
5.	Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах тогтолцоог бүрдүүлсэн байх	5.1.Үйлчлүүлэгчийн нууцыг хадгалдаг байх	1. Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг хадгалах, холбогдох баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг хийх журамтай 2. Байгууллагын бүх тасаг, нэгжид журмын хэрэгжилтийг хангаж, үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах зохион байгуулалтын арга хэмжээ авсан 3. Баримт бичгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавдаг 4. Эрүүл мэндийн ажилтан бүр мэддэг 5. Үйлчлүүлэгчтэй хийсэн ярилцлагын дүгнэлт	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	
		Авсан оноо	

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР**

БҮЛЭГ 1.ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэд бүлэг 4. ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ
а.Амбулаторын тусламж, үйлчилгээ				
1.	Амбулаториор үзлэг, оношилгоо, эмчилгээг хийж, зөвлөгөө өгдөг байна.	1.1.Амбулаторын үзлэгийн өрөөнүүдийг зохион байгуулж, үзлэг, оношилгоог бүрэн хийдэг байх	1. Батлагдсан бүтцийн дагуу амбулаторын үзлэгийн өрөөнүүд /кабинет/-ийг зохион байгуулсан 2. Үзлэг, шинжилгээ, оношилгоо, эмчилгээг стандарт, удирдамж, зааврын дагуу хийдэг 3. Кабинет бүрийг мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтнээр хангасан 4. Кабинет бүрийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан 5. Кабинет бүрт үйлчлүүлэгчид өвчин эмгэгийн талаар тайлбарлах, зөвлөгөө өгөхөд ашиглах зурагт самбар, биет үзүүлэн /муляж/, гарын авлагатай	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ:
		1.2.Үзлэгийн кабинетууд нь батлагдсан нормативт тохирсон ачаалалтай, үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай үйлчилгээ үзүүлдэг байх	1. Үзлэгийн кабинетуудын ачааллыг зохицуулж, үйлчлүүлэгчид товлосон цагт нь үйлчилгээ үзүүлдэг 2. Кабинетын үзлэгийн дарааллын мэдээлэл нь ил тод 3. Үзлэг, оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавьдаг 4. Хийгдсэн үзлэг, оношилгоо, эмчилгээ, өгсөн зөвлөгөөний талаар үйлчлүүлэгчийн картадтэмдэглэдэг 5. Анхан шатны бүртгэлийн маягт хөтөлдөг	5, 4, 3, 2, 0
		1.3.Амбулаториор хийгдэх ажилбар, үйлдлийн жагсаалттай байх	1. Амбулаториор хийгдэх ажилбар, үйлдлийн жагсаалтыг баталсан 2. Ажилбар, үйлдлийг батлагдсан стандарт, удирдамж, зааврын дагуу хийдэг 3. Эмнэлгийн мэргэжилтэн бүр өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу ажилбар, үйлдлийг хийх ур чадварыг эзэмшсэн, хийдэг 4. Эмнэлгийн мэргэжилтний гардан үйлдэл гүйцэтгэх ур	5, 4, 3, 2, 0

			<p>чадварт үнэлгээ хийдэг</p> <p>5. Үнэлгээний дүнгийн мөрөөр арга хэмжээ авдаг</p>	
		1.4. Өдрийн эмчилгээний нэгжтэй, үйлчүүлэгчид ээлтэй, тав тухтай орчинд эмчилгээ, үйлчилгээ хийдэг байх	<p>1. Өдрийн эмчилгээний нэгж, өрөөг зохион байгуулж, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр хангасан</p> <p>2. Хариуцсан эмнэлгийн мэргэжилтэнтэй</p> <p>3. Өдрийн эмчилгээ хийх журмыг мөрддөг</p> <p>4. Өдрөөр хийгдэх эмчилгээ, үйлчилгээний жагсаалттай</p> <p>5. Эмчийн заалтаар эмчилгээг хийдэг</p> <p>6. Анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлдөг</p> <p>7. Эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчийн бүртгэл, судалгаатай</p>	5, 4, 3, 2, 0
б. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ				
2.	Хүлээн авах, яаралтай тусламж, үйлчилгээг шуурхай, багаар үзүүлдэг байна.	2.1.Хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг /нэгж/ -ийг зохион байгуулж, орон тоогоор бүрэн ажиллуулсан, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх	<p>1. Хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг, нэгжийг зохион байгуулсан, ажиллах журамтай, мөрддөг</p> <p>2. Өвчтөнийг ажиглах болон тусгаарлах хэсгийг зохион байгуулсан</p> <p>3. Баталсан орон тоогоор бүрэн ажилладаг</p> <p>4. Яаралтай тусламж үзүүлэх багийг томилж, тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлж, тасралтгүй сургадаг</p> <p>5. Эмнэлгийн мэргэжилтнүүд багаар ажиллахад сургасан</p> <p>6. Анхан шатны бүртгэлийн маягтыг хөтөлдөг</p>	5, 4, 3, 2, 0
		2.2.Яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангасан байх	<p>1. Яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталсан</p> <p>2. Багаж, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангасан, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллуулж чаддаг, ур чадвар эзэмшсэн</p> <p>3. Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангасан, нөөцтэй</p> <p>4. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, зарцуулалт, нөхөн хангалтыг хийдэг</p> <p>5. Багаж, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтад хяналт тавьдаг</p>	5, 4, 3, 2, 0
		2.3.Эрэмбэлэн ангилах зарчмын дагуу үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгч, тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлдэг байх	<p>1. Эрэмбэлэн ангилах зарчмын дагуу үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгч, тусламж үйлчилгээг шуурхай, багаар үзүүлдэг</p> <p>2. Эмнэлгийн мэргэжилтнүүд эрэмбэлэн ангилах зарчмыг мэддэг, эзэмшсэн</p> <p>3. Эрэмбэлэн ангилалтын хуудсыг бүрэн хөтөлж,</p>	5, 4, 3, 2, 0

			судалгаа хийдэг	
		2.4.Яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх дуудлагын системтэй байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын хэмжээнд яаралтай үед ашиглах дуудлагын системтэй, шуурхай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн 2. Тусламж, үйлчилгээ үзүүлэх баг, эмнэлгийн мэргэжилтэнтэй шуурхай холбоо барих зохицуулалтыг хийсэн 3. Хэвтүүлэн эмчлэх тасаг, нэгж бүрт дуудлагын системтэй 4. Үйлчлүүлэгчийн ор бүрийн дэргэд дуудлагын хонхтой 	5, 4, 3, 2, 0
		2.5.Дүрс оношилгоо, лаборатори нь 24 цагаар үйлчилгээ үзүүлдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Дүрсношилгоо, лаборатори нь 24цагаар тусламж, үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтыг хийсэн 2. Оношилгоог шуурхай хийж, дүгнэлтийг холбогдох тасаг, нэгжид илгээж мэдээлдэг 	5, 4, 3, 2, 0
в.Түргэн тусламжийн үйлчилгээ				
3.	Түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдлыг хангасан байна.	3.1.Түргэн тусламж, үйлчилгээ үзүүлэх журамтай,дуудлагаар ажиллах эмнэлгийн мэргэжилтний хуваарийг баталж, мөрддөг байх	<ol style="list-style-type: none"> 1. Түргэн тусламж, үйлчилгээний баталсан журамтай, мөрддөг 2. Дуудлагаар ажиллах эмнэлгийн мэргэжилтний хуваарийг баталж, мөрддөг 3. Тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлдэг 	5, 4, 3, 2, 0
		3.2.Дуудлагын бүртгэл хөтөлдөг, дүгнэлт өгдөг байх	<ol style="list-style-type: none"> 1. Дуудлагын бүртгэл болон бусад анхан шатны бүртгэлийн маягыг хөтөлдөг 2. Түргэн тусламжийн дуудлага, үзүүлсэн тусламж, үйлчилгээнд хагас жил тутамд дүгнэлт өгч арга хэмжээ авдаг 	5, 4, 3, 2, 0
		3.3.Түргэн тусламжийн автомашинд тусламж үзүүлэхэд шаардлагатай багаж, эм, эмнэлгийн хэрэгслээр бүрэн хангасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Түргэн тусламжийн автомашинд байх багаж, эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг баталсан 2. Жагсаалтын дагуу бүрэн хангасан, нөхөн хангалтыг хийж, бүртгэдэг 	5, 4, 3, 2, 0
		3.4.Тусламж үзүүлэхэд шаардлагатай автомашин, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, дохиолол, дуудлагын системийг байрлуулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Автомашин,тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, дохиолол, дуудлагын систем байрлуулсан, хэвийн ажилладаг 2. Автомашин, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, дохиолол, дуудлагын системийн ажиллагааг хянах ажилтанг томилсон, бэлэн байдлыг хянаж, тэмдэглэл хөтөлдөг 	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо		
		Авсан оноо		

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР**

БҮЛЭГ 1.ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэд бүлэг 5. ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ
1.	Байгууллага нь халдварын сэргийлэлт, хяналтын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.	1.1. Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон халдварын сэргийлэлт, хяналт /ХСХ/-ын төлөвлөгөөтэй байх	<ol style="list-style-type: none"> 1. Төлөвлөгөөг тасаг, нэгж, тусламж үйлчилгээний чиглэл тус бүрээр, өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулж, баталсан 2. Төлөвлөгөө нь шинжлэх ухааны үндэслэлтэй, олон улсын болон өөрийн орны холбогдох хууль, дүрэм, зааварт нийцсэн 3. Эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгч, оюутан, эргэлтээр ирэгсэд, сахиурын дунд халдвар тархах эрсдлийг бууруулахад чиглэсэн 4. Төлөвлөгөөг байгууллагын ажилчдад танилцуулсан, мэддэг 5. ХСХ-ын тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг хөтөлбөрт тусгасан 6. Төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр хянадаг 7. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлантай 	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
		1.2. ХСХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллуулдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Тархвар судлаач эмч орон тоогоор ажилладаг ба 1 тархвар судлаачид ноогдох орны тоо 250 буюу түүнээс бага 2. ХСХ-ын асуудал хариуцсан эмч эсхүл сувилагчийг орон тоогоор ажиллуулдаг 3. Тасаг, нэгж бүрт халдвар хяналтын асуудалхариуцсан эмч, сувилагч ажилладаг 4. Эдгээр хүмүүст үндсэн ажлаас гадна ХСХ-ын үйл ажиллагаанд зарцуулах цагийн менежмент хийсэн 	5, 4, 3, 2,0
		1.3. ХСХ-ын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Хяналт, үнэлгээ хийх төлөвлөгөөтэй, хуваарийн дагуу сургагдсан мэргэжилтнүүд хяналт хийсэн 2. Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн цэвэрлэгээ, ариутгалд жилд 2-оос доошгүй удаа хяналт хийсэн 3. Эмнэлгийн орчны цэвэрлэгээнд улиралд 1-ээс доошгүй удаа хяналт хийсэн 4. Хог хаягдлын ангилан ялгалт, менежментэд улиралд 1-ээс 	5, 4, 3, 2,0

			доошгүй удаа хяналт хийсэн 5. Хяналт үнэлгээний дүнг ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулахад ашигласан	
		1.4. Эрүүл мэндийн ажилтан /ЭМА/-ы гарын эрүүл ахуй сахилтад хяналт, үнэлгээ хийсэн байх	1. Гар угаах нөхцлийг бүрдүүлсэн эсэхэд жилд 2-оос доошгүй удаа хяналт хийсэн 2. ЭМА-ы гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэгийг жилд 1-ээс доошгүй удаа үнэлсэн 3. Гарын эрүүл ахуй сахилтын ажиглалтын үнэлгээнд тусламж, үйлчилгээнд оролцож байгаа ЭМА-ныг бүрэн хамруулж, жилд 1-ээс доошгүй удаа хийж, түвшин тогтоосон 4. Спиртэнд суурьтай гар халдваргүйжүүлэх бүтээгдэхүүний хэрэглээнд улиралд 1-ээс доошгүй удаа хяналт хийдэг	5, 4, 3, 2,0
		1.5. Эрүүл мэндийн ажилтанд ХСХ-ын мэдлэг олгох сургалт хийдэг байх	1. ХСХ-ын чиглэлээр сургагч багшаар бэлтгэгдсэн, эсхүл дадлага туршлагатай мэргэжилтэн сургалт хийдэг 2. Сургалтыг үр дүнтэй явуулах арга, хэрэгсэл, өөрөө бие даан сурах боломжийг хангасан 3. Шинэ ажилтанд ХСХ-ын чиглэлээр чиг баримжаа олгох сургалт хийдэг, сургалтын хэрэгсэл, материалтай 4. Антибиотикийн зохистой хэрэглээ, нянгийн тэсвэржилтийн талаар жилд 2-оос доошгүй удаа сургалт хийж эмч, лабораторийн мэргэжилтнүүдийг хамруулсан 5. Сургалтын үр дүнг ажлын байран дээр үнэлж дүгнэсэн	5, 4, 3, 2,0
		1.6. Эрүүл мэндийн ажилтан дараахь дадлыг эзэмшсэн байх	1. Гарын эрүүл ахуйн сургалтанд хамруулсан, зөв угааж, халдваргүйжүүлэх дадал эзэмшсэн 2. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалтанд хамруулсан, хог хаягдлыг зөв ангилсан 3. Дэгдэлтийн менежмент бэлэн байдлыг хангах чиглэлээр сургалт хийсэн 4. Хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөж, тайлах дадал эзэмшсэн	5, 4, 3, 2,0
2.	Эрүүл мэндийн ажилтан /ЭМА/ болон үйлчлүүлэгчийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний	2.1. Үйлчлүүлэгч халдварт өртөх эрсдэлтэй ажилбарыг тогтоосон байх	1. Байгууллагад хийгдэж байгаа халдварын эрсдэл өндөртэй ажилбарын жагсаалтыг гаргасан 2. Халдварын эрсдэл өндөртэй ажилбаруудын гүйцэтгэл, үйл ажиллагаанд шалгах хуудас ашиглан улирал бүр хяналт хийсэн 3. Алдаа, дутагдлыг илрүүлэн шалтгааныг тогтоож, арилгуулах арга хэмжээ авсан	5, 4, 3, 2,0
		2.2. ЭМА-ы халдварт өртөх	1. ЭМА-ы халдварт өртөх эрсдэл өндөртэй тасаг, нэгж, ажилбарыг	5, 4, 3, 2,0

	явцад халдварт өртөх эрсдлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа хийдэг байна.	эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх аргахэмжээавдагбайх	<p>тогтоосон</p> <ol style="list-style-type: none"> Тухайн тасаг нэгжид ажиллаж байгаа ЭМА халдвараас сэргийлэх мэдлэг, дадалтай болсон Хувийн хамгаалах хэрэгслээр тасралтгүй хангадаг ЭМА-ы гарын арьс хуурайших, хагарахаас сэргийлж гар угаах, халдваргүйжүүлэх бүтээгдэхүүн харшил, хуурайшуулах нөлөө үзүүлж байгаа эсэхийг судалдаг Харшил өгдөг, хуурайшуулж арьсанд гэмтэл өгдөг бол бүтээгдэхүүнийг өөрчлөх арга хэмжээ авсан 	
	2.3.Халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн бол халдвараас сэргийлэх арга хэмжээ авсан байх	<ol style="list-style-type: none"> Халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдлыг бүртгэсэн Халдвараас сэргийлэх арга хэмжээ авсан Өртөлтийн дараах сэргийлэлтэд шаардагдах хэрэгслээр хангагдсан цомогтой Гепатитийн В, С вирус, ХДХВ илрүүлэх тестээр илрүүлэг хийх мэргэжилтэнг сургасан В гепатитын дархлаажуулалтад 48 цагийн дотор хамрагдах боломжтой 	5, 4, 3, 2,0	
	2.4.Нярай, дархлаа дарангуйлагдсан үйлчлүүлэгч, эрчимт эмчилгээ, түлэгдсэн зэрэг эмзэг бүлгийн үйлчлүүлэгчийг халдварт өртөхөөс сэргийлдэг байх	<ol style="list-style-type: none"> Өөрийн үйл ажиллагаанд тохируулан гаргасан журамтай Тухайн тасаг, нэгжийн халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд хяналт хийсэн Дархлаа дарангуйлагдсан үйлчлүүлэгчийг тусгаарлаж эмчлэх боломжтой Хоёрдогч халдвар, олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвар илэрсэн үед тасаг нэгжид нь тусгаарлаж эмчилдэг 	5, 4, 3, 2,0	
	2.5.Ажилбарын өрөө бүрт гаругаах нөхцлийг бүрдүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> Ажилбар хийгддэг өрөө бүрт гар угаах угаалтууртай Угаалтуур нь гар угаасны дараа гар оролцохгүй хаах боломжтой Угаалтуур нь халуун, хүйтэн устай, цэвэр бохир усны төвлөрсөн шугамд холбогдсон Угаалтуур бүр шингэн савантай Нэг удаагийн цаасан алчуур хэрэглэдэг Угаалтуур эвдрэл гэмтэлгүй ажилладаг 	5, 4, 3, 2,0	
	2.6.Тусламж, үйлчилгээ үзүүлэх цэг бүрт гар халдваргүйжүүлэх бодистой байх	<ol style="list-style-type: none"> Тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа цэгүүдэд шахуурга бүхий гар халдваргүйжүүлэх бодистой Гар халдваргүйжүүлэх бодисын спиртын агууламж 70-80 хувьтай Бодис нь улсын бүртгэлд бүртгэгдсэн 	5, 4, 3, 2,0	

3.	Эмнэлгийн ажилтны эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хийдэг байна.	3.1. Эмнэлгийн ажилтныг жилд 1-ээс доошгүй удаа халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. ЭМА-ыг жилд 1 удаа үзлэг, шинжилгээнд хамруулсан /Сүрьеэ, гепатитийн В, С, D вирус, ХДХВ, Метициллин тэсвэртэй Staphylococcus aureus илрүүлэх үзлэг, шинжилгээ багтсан байх/ 2. Гепатитийн В, С вирусын архаг халдвартай ажилтанг эмчилгээнд хамруулсан 3. Гепатитийн В, С вирусын архаг халдвартай ажилтанг вирусын идэвхижил тодорхойлох шинжилгээнд жил бүр хамруулсан 4. Эмнэлгийн ажилтны эмчийг томилж ажиллуулдаг 5. Зарим халдварын үед ажлын байрны зохицуулалт, хязгаарлалт хийдэг 6. ЭМА-ы түр амрах, алжаал тайлах өрөөтэй 	5, 4, 3, 2,0
		3.2. Шинэ ажилтанг урьдчилан үзлэг шинжилгээнд хамруулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Үзлэг, шинжилгээнд хамруулж, “Ажилтны эрүүл мэндийн хуудас”-ыг хөтөлж, хуудсыг хувийн хэрэгт хавсаргасан 2. В, С, D вирүст гепатит, ХДХВ, сүрьеэгийн халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан 3. В гепатит, улаанбурхан, гахай хавдар, улаануудын дархлаажуулалтад хамрагдсан эсэх мэдээллийг авсан 4. В гепатит, улаанбурхан, гахай хавдар, улаануудын вакцинд хамрагдаагүй бол дархлаажуулах, хамрагдсан бол дархлаа тогтоцыг үзүүлсэн 5. Салхинцэцэгээр өвдсөн эсэх мэдээллийг авсан 	5, 4, 3, 2,0
		3.3. Эмнэлгийн ажилтны дархлаажуулалтын нэгдсэн бүртгэл, судалгаатай, дархлаажуулалтад хамруулдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. ЭМА-нд хийсэн дархлаажуулалтын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай 2. Архаг халдваргүй, эсрэг заалтгүй бол эмнэлгийн ажилтанг В вируст гепатитийн 3 тун вакцинаар дархлаажуулсан 3. В вируст гепатитийн дархлаажуулалтад хамрагдсан ажилтныг дархлаа тогтоцын шинжилгээнд хамруулсан 4. Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын дархлаажуулалтанд хамрагдсан, өвдсөн бол дархлаа тогтоцын шинжилгээнд хамрагдсан 5. Тусламж, үйлчилгээнд оролцон ажиллаж байгаа ажилтанг улирлын томуугийн вакцинд хамруулсан 	5, 4, 3, 2,0
		3.4. Эрүүлмэндийн ажилтныг дүрэмт болон хамгаалах хувцас, хэрэгслээр хангасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Ажилтны ажлын хувцас (халад, өмд цамц) 2 ээлжээс багагүй байх 2. Ажлын хувцас биеийн хэмжээнд тохирсон, даавуун материалаар хийгдсэн 3. Ажлын хувцсыг угаах асуудлыг шийдвэрлэсэн 4. Эмнэлэгт өмсөх урдуураа битүү гутал, углаашаар хангасан 5. Нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгсэл тасаг, нэгжүүдэд 	5, 4, 3, 2,0

			хүрэлцээтэй	
4.	Ариутгалын тасаг, нэгжийг ажиллуулж цэвэр, ариун аюулгүй байдлыг хангасан багаж, хэрэгслээр тусламж, үйлчилгээ үзүүлнэ.	4.1. Ариутгалын нэгдсэн тасаг/нэгжтэй, эмнэлгийн үйл ажиллагаанд нийцсэн ариутгалын заавартай байх	<ol style="list-style-type: none"> 1. Ариутгалын тасаг, нэгжтэй 2. Өрөө тасалгаа хүрэлцээтэй, өрөөний урсгалыг зөв зохион байгуулсан, эрүүл ахуйн шаардлага хангасан 3. Цахилгаан хангамж, усны шугам, агааржуулалт гэх мэт шаардлагатай дэд бүтцийг бүрдүүлсэн 4. Давтан ашиглах багаж хэрэгсэл, материалын жагсаалтыг тасаг нэгж тус бүрээр гаргасан 5. Ариутгалын тасагт ажиллагсад нь мэргэжил олгох сургалтад хамрагдсан 	5, 4, 3, 2,0
		4.2. Ариутгалын тасаг, нэгж нь эмнэлгийн багаж, хэрэгслийг ариутгах боломжтой шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Тоног төхөөрөмжийн ажиллагаа нь доголдолгүй 2. Бохир багаж хэрэгслийг гараар угаах хэрэгслээр болон зориулалтын угаах автомат машинтай 3. Хатаах шүүгээ эсвэл өрөөний хэмд хатаах тавиур, ширээ, арчиж хатаах даавуун алчуураар хангагдсан 4. Өөрийн үйл ажиллагааг хянадаг автомат тохируулга бүхий 2-оос доошгүй автоклавтай 5. Бага хэмийн ариутгагчтай 6. Ус нэрэгч болон ус шүүх төхөөрөмжтэй 7. Багаж хэрэгслийг зориулалтын боолтын материалаар боож, савладаг 8. Томруулах шил, хөндийтэй багаж хэрэгслийг сэтгүүрдэж угаах сойз гэх мэт бусад дагалдах хэрэгслээр хангасан 	5, 4, 3, 2,0
		4.3. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд улсын бүртгэлд бүртгэгдсэн бодисыг зориулалтын дагуу ашигладаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Багажийн угаалганд биологийн бохирдол арилгах бодис ашигладаг 2. Бүртгэлийн гэрчилгээтэй цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх бодисуудыг ашигладаг 3. Бодисыг батлагдсан зааврын дагуу найруулж, хэрэглэдэг 	5, 4, 3, 2,0
3.	Тусламж, үйлчилгээний аюулгүй байдал,	3.1.Ажлын байрны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөтэй ажилладаг байх	1. Ажлын байрны орчинд үнэлгээ хийлгэсэн, орчинг сайжруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн 2. Ажиллах орчинд үүсч болох эрсдлээс сэргийлэх	5, 4, 3, 2, 0

	гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталж, дүн шинжилгээ хийдэг байна.		сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлсэн 3. Ажилтан бүрийг хувийн хамгаалах хэрэгслээр хангасан, хэрэглэж хэвшсэн	
		3.2.Цацрагийн үүсгүүртэй рентген тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тоног төхөөрөмж, өрөө тасалгааг жил бүр мэргэжлийн байгууллагаар үнэлүүлдэг байх	1. Цацрагийн үүсгүүр буюу компьютерт томограф, рентген тоног төхөөрөмж тус бүр нь ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөлтэй 2. Өрөө тасалгаа, тоног төхөөрөмжид цацрагийн тунгийн хэмжилтийг тогтмол хийлгэсэн 3. Цацрагийн болон рентген тоног төхөөрөмжийн туяаны тун зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд цацрагийн хяналтын газар болон бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлттэй	5, 4, 3, 2, 0
		3.3.Үйлчүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байх	1. Үйлчүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, орчны эрсдлийн үнэлгээ хийсэн, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн 2. Үйлчүүлэгчид аюулгүй байдлын талаар мэдээлэл, зөвлөгөө өгдөг 3. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн	5, 4, 3, 2, 0
		3.4.Ионжуулагч цацрагийн буюу рентген туяаны хор нөлөөнөөс сэргийлэх санамж, сэрэмжлүүлгийг ажлын байр, үйлчилгээний орчинд ил байрлуулсан байх	1. Рентген туяаны санамж, анхааруулга тэмдгийг үйлчилгээний орчинд ил, харагдахуйц байршуулсан	5, 4, 3, 2, 0
		3.5.Үйлчлүүлэгчийн оношилгоотой холбоотой баримт бичиг, цахим мэдээллийн нууцыг хадгалдаг байх	1. Баримт бичгийн нууцлалыг хадгалсан 2. Цахим мэдээллийн нууцлалыг хадгалах арга хэмжээ авсан	5, 4, 3, 2, 0
		3.6.Цахим сүлжээ, системийн аюулгүй байдлыг хангаж ажилладаг байх	1. Цахим сүлжээний нууцлалыг хадгалдаг 2. Цахим мэдээний сан үүсгэлт, баталгаажуулалт, мэдээлэл авах эрх, хязгаарлалтыг зохицуулсан 3. Цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, архивлалтыг хийсэн	5, 4, 3, 2, 0
4.	Тусламж, үйлчилгээний технологи, стандарт,	4.1.Дүрс оношилгооны тусламж, үйлчилгээний жагсаалт гарган мөрддөг байх	1. Жил бүр тусламж, үйлчилгээний жагсаалт гарган байгууллагын даргаар баталгаажуулан, гадаад, дотоод үйлчүүлэгчид ил тод мэдээлдэг	5, 4, 3, 2, 0

удирдамж, зааврыг мөрддөг байна.	4.2.Мэргэшсэн дүрс оношилгооны эмч/техникч дүрс оношилгооны бүх үйлдлийг хариуцдаг байх	1. Дүрс оношилгооны бүх үйлдлийг мэргэжлийн техникч гүйцэтгэдэг 2. Бүх зургийг мэргэжлийн эмч уншиж, дүгнэлт бичдэг	5, 4, 3, 2, 0
	4.3.Тусламж, үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарь баталж, мөрдөж ажилладаг байх	1. Ажиллах цагийн хуваарийг баталсан, мөрддөг 2. Үйлчилгээний танхимуудад ил, харагдахуйц байршуулсан	5, 4, 3, 2, 0
	4.4.Эмч, мэргэжилтнүүд нь оношилгооны арга техникийн бүрэн эзэмшсэн байх	1. Оношилгооны нэр төрлийн жагсаалттай заавартай 2. Оношилгооны аргачлал, заавартай 3. Оношилгооны нэр төрөлбүр дээр гардан ажиллаж чадах эмч, мэргэжилтний жагсаалтыг гаргасан 4. Шаардлагатай үед хавсран, хослон ажиллах эмч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, мэдлэг, ур чадвар эзэмшүүлсэн	5, 4, 3, 2, 0
	4.5.Шинжилгээний өмнөх, шинжилгээний, шинжилгээний дараахь гүйцэтгэлийг үнэлэх чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлж, хяналт тавин үр дүнг тооцон ажилладаг байх	1. Шинжилгээний өмнөх, шинжилгээний, шинжилгээний дараах үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтээ тодорхойлсон 2. Сар, улирлаар үзүүлэлтийг дүгнэн хамт олонд мэдээлсэн 3. Жил бүр шалгуур үзүүлэлтээ хэлэлцэн шинэчлэн сайжруулдаг	5, 4, 3, 2, 0
	4.6.Шинжилгээний тодотгогч бодис зэрэг дүрс оношилгоонд хэрэглэгддэг эмэнд хэт мэдрэг үйлчлүүлэгчид үзүүлэх эмчилгээний заавартай байх	2. Эмчилгээний зааврыг боловсруулж, баталсан 3. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулсан, ашигладаг 4. Гарын авлагаар хангасан	5, 4, 3, 2, 0
	4.7.Рентген туяагаар үйлчилгээ үзүүлж байгаа үед туяаны хамгаалалтыг хийдэг байх	1. Холбогдох журам, заавартай 2. Туяаны хамгаалалтыг хийдэг	5, 4, 3, 2, 0
	4.8.Туяаны аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээ авч ажилладаг байх	3. Туяаны аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээний хүрээнд цахилгаан, гал, дэлбэрэлт, туяаны хорны нөлөөнөөс сэргийлж авсан арга хэмжээ, баримтжуулалт	5, 4, 3, 2, 0
	4.9.Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй ажиллах ажилтанг хувцас, хяналтын багаж хэрэгслээр хангагдсан, хүртээмжтэй байх	1. Ажилтныг хувцас, багаж хэрэгслээр хангасан, тэдгээр нь шаардлага хангасан	5, 4, 3, 2, 0

5.	Яаралтай шинжилгээ хийх, хариуг мэдээллэх үйл явцыг баталгаажуулдаг байна.	5.1.Яаралтай шинжилгээ хийх, журамтай, мөрддөг байх	<ol style="list-style-type: none"> 1. Яаралтай шинжилгээ, өндөр эрсдэлтэй хариуг мэдээллэх батлагдсан журамтай 2. Батлагдсан журмыг эмч, ажилтнууд танилцуулсан, мэддэг, мөрддөг 3. Яаралтай шинжилгээ, оношилгооны бүртгэлтэй 	5, 4, 3, 2, 0
6.	Урвалж, тодотгогч бодисын хангалт, чанар, аюулгүй байдлыг хангасан байна.	6.1.Оношилгоонд шаардлагатай тодотгогч бодисоор бүрэн хангасан, хүрэлцээтэй нөөцтэй байх	1. Оношилгоонд хэрэглэх тодотгогч бодисын нөөцийг тооцоолон жил бүр байгууллагын дарга баталж, хангалт хийсэн	5, 4, 3, 2, 0
		6.2.Тодотгогч бодисын чанарын баталгаа, шинжилгээнд хэрэглэх үеийн аюулгүй ажиллагааг хангасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Тендерээр болон гэрээгээр нийлүүлсэн бодисын чанарын гэрчилгээтэй 2. Үйлдвэрлэгчийн зааврын дагуу зөв хадгалдаг, шинжилгээнд ашигладаг 3. Зарцуулалтын бүртгэл хөтөлдөг 	5, 4, 3, 2, 0
7.	Оношилгооны тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалт, аюулгүй ажиллагааг хангасан байна.	7.1.Тусламж, үйлчилгээний шатлал /Тусгай зөвшөөрөлд заасан чиглэл/-д тохирсон дүрс оношилгооны тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Стандартад заагдсан байвал зохих тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан 2. Стандарт заагдсан тоног төхөөрөмжийн хангалтын хувь 	5, 4, 3, 2, 0
		7.2.Тоног төхөөрөмж ханган нийлүүлэгчтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, үйлчилгээ засварыг бүрэн хийлгэдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Тоног төхөөрөмжийг худалдан авсан компанитай гэрээ байгуулсан 2. Ханган нийлүүлэгч бүртэй хийсэн гэрээтэй, гэрээнд суурилуулалт, тохируулга, эмч, ажилчдыг сургах, ажиллуулах зааврыг Монгол хэл дээр орчуулсан 3. Ханган нийлүүлэгчээс хийх үйлчилгээ, шаардлагатай үед хийх засварыг хоёр тал хэрхэн хариуцахыг гэрээнд тодорхой заасан 4. Гэрээний дагуу суурилуулалт, тохиргоо, сургалт, үйлчилгээ, засвар хийж, баримтжуулсан 5. Үйлчигээ, засварын төсвийг төсөвлөн, зарцуулсан 	5, 4, 3, 2, 0
		7.3.Тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн буюу ханган нийлүүлэгчийн зааврын дагуу үйлчилгээ, хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Эмч, мэргэжилтнүүд тоног төхөөрөмж ажиллуулах сургалтад бүрэн хамрагдсан 2. Тоног төхөөрөмж бүрт тохируулга, үйлчилгээ, засвар хийсэн бүртгэлтэй 	5, 4, 3, 2, 0

			<ul style="list-style-type: none"> 3. Тоног төхөөрөмж бүрийг ажиллуулах заавар боловсруулж, батлуулан мөрдөж ажилладаг 4. Тоног төхөөрөмж бүрт зааврын дагуу үйлчилгээг хийн баримтжуулсан 5. Эвдрэл гэмтэл гарсан тоног төхөөрөмжийн тоо, хувь 6. Зарцуулсан хөрөнгийн тооцоо 	
	7.4.Техникийн шаардлага хангасан /Рентген, ЭХО гм/ тоног төхөөрөмжүүдийг ашигладаг байх		<ul style="list-style-type: none"> 1. Тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг гаргаж, баталгаажуулсан 2. Хэмжилт, баталгаажилтыг тогтмол хийлгэдэг 	5, 4, 3, 2, 0
Онооны дүн	Авбал зохих оноо		...	
	Авсан оноо		...	

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР**

**БҮЛЭГЗ. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Дэд бүлэг 22. СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ
1.	Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, нэгжийг зохион байгуулж, тушаал шийдвэрийг хэрэгжүүлдэг байна.	1.1.Тусламж, үйлчилгээ үзүүлж буй тасаг, нэгжийг стандарт шаардлагын дагуу зохион байгуулсан байх	1. Байгууллагын мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, нэгжийг зохион байгуулсан 2. Тусламж, үйлчилгээг үзүүлэх журамтай, мөрддөг	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
		1.2.Сэргээн засах тусламж, үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх, амбулаторийн болон өдрийн хэлбэрээр үзүүлдэг байх	1. Сэргээн засах тусламж, үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх, амбулаторийн болон өдрийн хэлбэрээр үзүүлэх зохион байгуулалт хийсэн 2. Тасаг, нэгжийг тус тусад нь зохион байгуулсан	5, 4, 3, 2, 0
		1.3.Амбулатори болон өдрийн эмчилгээ хийх хэсгийг зохион байгуулсан, эмнэлгийн мэргэжилтэн, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх	1. Амбулаторийн болон өдрийн эмчилгээний өрөөтэй 2. Өрөөний талбайн хэмжээ, өнгө будаг, агааржуулалт, гэрэлтүүлэг, өрөөний дулаан нь стандартын шаардлага хангасан 3. Эмч, сувилагч орон тоогоор ажиллуулдаг 4. Эмчилгээ хийхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангасан 5. Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангасан	5, 4, 3, 2, 0
		1.4.Тасаг, нэгжийн үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээг зохицуулах журамтай, хэрэгжилтэд хяналт тавьдаг байх	1. Тасаг, нэгжийн үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээг зохицуулах батлагдсан журамтай 2. Хэрэгжилтэд хяналт тавьдаг 3. Хийгдэх оношилгоо, эмчилгээ, үйлдлийн	5, 4, 3, 2, 0

			жагсаалтыг баталсан, мөрддөг	
		1.5.Үйлчлүүлэгчийг хүлээн авах, шилжүүлэх, эмнэлгээс гаргах, эргэн хянах журмыг хэрэгжүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын баталсан үйлчлүүлэгчийг хүлээн авах, шилжүүлэх, эмнэлгээс гаргах, эргэн хянах журмыг мөрддөг 2. Хүлээн авсан, шилжүүлсэн, эмнэлгээс гаргасан, эргэн хянасан үйлчлүүлэгчийн бүртгэлтэй, дүгнэлт өгдөг 3. Анхан шатны бүртгэлийн маягтуудыг хөтөлдөг 	5, 4, 3, 2, 0
2.	Эмнэлгийн мэргэжилтний мэргэшил, ур чадварыг дээшлүүлж, ажлын гүйцэтгэлийг үнэлдэг байна.	2.1.Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн, ур чадвартай эмнэлгийн мэргэжилтнээр хангасан байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандартад заасан орон тоогоор хангасан хувь 2. Эмнэлгийн мэргэжилтнүүд хүчинтэй хугацаа бүхий мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 3. Эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэшсэн 4. Эмнэлгийн мэргэжилтнүүд ур чадвар эзэмшсэн, ур чадварыг үнэлдэг 	5, 4, 3, 2, 0
		2.2.Эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтад хамруулж, ур чадварыг дээшлүүлдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Сургалтад хамрагдсан бүртгэл, мэдээлэлтэй 2. Мэргэжлийн үнэмлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан мэргэжилтний хувь /он тус бүрээр/ 3. Мэргэжлийн зэрэг, эрдмийн цол зэрэг хамгаалсан мэргэжилтний тоо/хувь нэмэгдсэн 	5, 4, 3, 2, 0
		2.3.Шинэ ажилтанг чиглүүлэх, дадлагажуулах сургалтад хамруулсан, дэмжлэг үзүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Чиглүүлэх, дадлагажуулах сургалтын хөтөлбөртэй 2. Сургалт хийсэн, үр дүнг дүгнэсэн 3. Тайлан, баримтжуулалт хийсэн 4. Ажилтантай хийсэн ярилцлагын дүгнэлт, дүн 	5, 4, 3, 2, 0
		2.4.Эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийж, дүгнэлт өгдөг байх	<ol style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлд батлагдсан журам, шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийсэн 2. Үнэлгээг ажилтанд танилцуулж баталгаажуулсан 3. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тайлантай 4. Гүйцэтгэлийг үндэслэн урамшуулдаг 	5, 4, 3, 2, 0
3.	Тусламж,	3.1.Байгууллагын хэмжээнд зохион	1. Ажилтан бүрийн албан тушаалын	5, 4, 3, 2, 0

	<p>үйлчилгээний чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулдаг байна.</p>	<p>байгуулсан чанар сайжруулах үйл ажиллагаанд оролцдог байх</p>	<p>тодорхойлолтод чанар сайжруулах үйл ажиллагааны оролцоог тусгасан</p> <ol style="list-style-type: none"> 2. Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, баримттай 3. Ажилтны ажлын тайланд тусгасан 	
		<p>3.2.Тасаг, нэгжид тусламж, үйлчилгээний чанараа сайжруулах олон талт ажлыг төлөвлөн зохион байгуулдаг байх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны баталсан төлөвлөгөөтэй 2. Хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дүгнэдэг, тайлантай 3. Ажилтнуудын оролцоог хангасан, баримжуулалт 	<p>5, 4, 3, 2, 0</p>
		<p>3.3.Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтэд тогтмол дүн шинжилгээ хийж, сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг байх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тасаг, нэгжийн үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг илтгэх шалгуур үзүүлэлтийг баталсан 2. Үзүүлэлтүүдэд тогтмол хэмжилт, дүн шинжилгээ хийсэн, тайлантай 3. Сайжруулах ажлыг хийсэн, үр дүнг тооцдог 	<p>5, 4, 3, 2, 0</p>
<p>4.</p>	<p>Тусламж, үйлчилгээний технологийг мөрдөж, аюулгүй байдлыг хангасан байна.</p>	<p>4.1. Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх оношилгоо, үнэлгээний жагсаалтад заасан нэр төрлөөр оношилгоо, үнэлгээхийдэг байх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Өөрийн байгууллагын үзүүлдэг сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх оношилгоо, үнэлгээнийжагсаалтыг баталсан 2. Жагсаалтад заасан тусламж, үйлчилгээг үзүүлдэг 3. Оношилгоо, үнэлгээ хийсэн үйлчлүүлэгчийн өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгдөг 4. Сэргээн засах тусламж, үйлчилгээнд оношилгоо, үнэлгээгээр өвдөлтийн хүч, шинж чанар, биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын түвшин, чадвар алдагдлын түвшин, нийгмийн оролцооны хязгаарлагдмал байдал, орчны болон хувь хүний хүчин зүйл, амьдралын чанарын түвшин зэрэг үзүүлэлтийг тодорхойлдог 5. Анхан шатны бүртгэлийн маягтын хөтлөлт 	<p>5, 4, 3, 2, 0</p>

	4.2. Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх эмчилгээний жагсаалтад заасан эмчилгээг хийдэг байх	1. Өөрийн байгууллагын үзүүлдэг сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх эмчилгээний жагсаалтыг баталсан 2. Жагсаалтад заасан нэр төрөл бүрээр эмчилгээ хийсэн бүртгэлтэй 3. Анхан шатны бүртгэлийн маягтын хөтлөлт	5, 4, 3, 2, 0
	4.3. Оношилгоо, үнэлгээ, эмчилгээг стандарт, эмнэлзүйн зааврын дагуу хийдэг байх	1. Оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, эмнэлзүйн заавраар эмнэлгийн мэргэжилтнүүдийг хангасан 2. Оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, зааврыг мөрддөг 3. Оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, зааврын мөрдөлтөд хяналт тавьдаг, сайжруулах арга хэмжээ авдаг 4. Сургалт зохион байгуулдаг	5, 4, 3, 2, 0
	4.4. Сэргээн засах тусламж, үйлчилгээний үр дүнг тооцдог байх	1. Сэргээн засах тусламж, үйлчилгээний үр дүнг дүгнэдэг 2. Үр дүнгийн харьцуулсан дүгнэлт, судалгаатай	5, 4, 3, 2, 0
	4.5. Хэвтэн эмчлүүлсэн өвчтөний оношийн бүлгээр ангилан, дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгдөг байх	1. Хэвтэн эмчлүүлсэн өвчтөний оношийн бүлгээр ангилан, дүгнэлт өгдөг	5, 4, 3, 2, 0
	4.6. Эмнэлгийн мэргэжилтнүүд нь оношилгоо, үнэлгээ, эмчилгээ хийх технологийг бүрэн эзэмшсэн байх	1. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн технологи, аргачлалыг гүйцэтгэх ур чадварт хяналтын хуудсаар үнэлгээ өгдөг 2. Хийгдсэн ажилбар, үйлдлийг өвчний түүхэнд тэмдэглэдэг, холбогдох баримт бичгийг хөтөлдөг	5, 4, 3, 2, 0
	4.7. Ноцтой хүндрэл гарах эрсдэлтэй, хүнд, маш хүнд өвчтний оношилгоо эмчилгээг шийдвэрлэхэд эмч нарын хамтарсан үзлэг, хэлэлцүүлэг хийдэг байх	1. Эмч нарын хамтарсан үзлэг, хэлэлцүүлэг хийх журмыг мөрддөг 2. Хамтарсан үзлэг, хэлэлцүүлэг хийсэн тохиолдолд дүгнэлт, шийдвэрийг бичиж баталгаажуулдаг 3. Хамтарсан үзлэгийн тэмдэглэл, бүртгэл хөтөлдөг	5, 4, 3, 2, 0
5.	Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг үзүүлж, аюулгүй байдлыг	5.1. Ямар нэгэн ажилбар, үйлдэл хийхийн өмнө үйлчлүүлэгчийг таньдаг байх 1. Байгууллагын баталсан үйлчлүүлэгчийг зөв таних журмыг хэрэгжүүлдэг 2. Оношилгоо, эмчилгээний ажилбар, үйлдэл	5, 4, 3, 2, 0

	хангаж ажиллана.		бүрийн өмнө үйлчлүүлэгчийг зөв таних аргыг ашигладаг	
		5.2.Үйлчлүүлэгчийг явганаас унах эрсдлээс сэргийлсэн арга хэмжээ авсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын баталсан журмыг мөрддөг 2. Унах эрсдэлтэй үйлчлүүлэгч, сэргийлэх аргыг тодорхойлсон, ашигладаг 3. Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчийг тогтоож, хяналт тавьдаг 4. Үйлчлүүлэгчийг унах эрсдлээс сэргийлсэн орчинг бүрдүүлсэн /үйлчлүүлэгчийн өрөө, шат, хаалганы довжоо, ариун цэврийн өрөө, шал/ 5. Үйлчлүүлэгчийг унах эрсдлээс сэргийлсэн анхааруулга таних тэмдэг, тэмдэглэгээ хийсэн 	5, 4, 3, 2, 0
		5.3.Үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийнхэнд хийгдэх эмчилгээ, оношилгооны талаар танилцуулж, зөвлөгөө өгдөг байх	<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгчид өвчин, эмгэгийн байдал, хийгдэх оношилгоо, эмчилгээний талаар танилцуулж, зөвлөгөө өгдөг 2. Үйлчлүүлэгчийн гэр бүлийнхэнд, хийгдэх оношилгоо, эмчилгээний талаар танилцуулж, санал солилцдог, бүртгэлтэй 3. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл сургалт, сурталчилгаа хийдэг 	5, 4, 3, 2, 0
		5.4.Үйлчлүүлэгч тусламж, үйлчилгээ авах дуудлагын системтэй байх	<ol style="list-style-type: none"> 1. Яаралтай үед тусламж үзүүлэх баг дуудах дуудлагын ситсемтэй 2. Үйлчлүүлэгч бүрийн орны дэргэд дуудлагын хонхтой 3. Эмч, сувилагч нардуудлага хүлээн авч, тусламж үйлчилгээг шуурхай үзүүлдэг 	5, 4, 3, 2, 0
6.	Тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангасан байна.	6.1.Үзлэг, оношилгоо, эмчилгээнд хэрэглэх төхөөрөмжүүд нь хүрэлцэхүйц, бэлэн, эмчилгээний стандарттай нийцдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Оношилгоо, эмчилгээнд ашиглах багаж, тоног төхөөрөмжийн жагсаалттай 2. Багаж, тоног төхөөрөмжүүд нь хэвийн ажиллагаатай 3. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд тоног төхөөрөмжийн ажиллах заавар, аюулгүй ажиллагааны талаар сургалт хийдэг 4. Ажлын байранд тоног төхөөрөмжийн ажиллах болон аюулгүй ажиллагааны заавартай 	5, 4, 3, 2, 0

			<p>5. Багаж, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хянадаг зохицуулалт хийсэн</p> <p>6. Багаж, тоног төхөөрөмжид тогтмол үзлэг, засвар үйлчилгээг хийж, тэмдэглэл хөтөлдөг</p>	
	Онооны дүн	Авбал зохих оноо	...	
		Авсан оноо	...	

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ШИНЖЛЭХ ШАЛГУУР**

**БҮЛЭГЗ. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Дэд бүлэг 23.ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭЛГЭЭ
1.	Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээтэй холбоотой зохицуулалтыг хийж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлсэн байна.	1.1.Байгууллага нь цус, цусан бүтээгдэхүүн /ЦЦБ/-ий үйлдвэрлэл, хэрэглээг зохицуулах журамтай, алба, нэгжийг байгуулан, үйл ажиллагаа, тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьдаг байх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандарт, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн алба, тасаг, нэгж, өрөөгзөв, урсгалаар зохион байгуулсан 2. Хариуцах удирдлага,эмч, мэргэжилтэнг тушаалаар томилж, мэргэшүүлэх сургалтанд бүрэн хамруулсан 3. Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг зохицуулах батлагдсан журамтай, үйл ажиллагаанд дагаж мөрддөг 4. Хэрэгжилтэд тогтмол хугацаанд хяналт тавьдаг, хяналтын үр дүн, зөвлөмж, зөвлөгөө өгч баримтжуулсан 5. Харьяа эрүүл мэндийн байгууллага, сумдыг мэргэжил арга зүйгээр хангаж, сургалт зохион байгуулдаг 	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ
2.	Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чанарын шаардлагыг хангаж, донорыг бэлтгэх, ЦЦБ цуглуулах ажлыг зохион	2.1.Хэрэгцээнд тулгуурласан ЦЦБ үйлдвэрлэх төлөвлөгөөтэй, хэрэгжилтэнд тогтмол дүн шинжилгээ хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. ЦЦБ хэрэглээ, хэрэгцээний судалгаа, дүгнэлттэй 2. Судалгаанд үндэслэн ЦЦБ үйлдвэрлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажилладаг 3. ЦЦБ үйлдвэрлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр дүн шинжилгээ хийдэг 4. Цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээ, хэрэглээтэй холбоотой асуудлыг байгууллагын удирдлагын түвшинд хэлэлцүүлж, асуудлыг шийдвэрлүүлсэн, баримтжуулалт 	5, 4, 3, 2, 0

байгуулдаг байна.	2.2.Батлагдсан журам, зааврын дагуу аюулгүй, чанартай, хүрэлцээтэй ЦЦБ үйлдвэрлэж, баримтжуулсан байх	<ol style="list-style-type: none"> 1. ЦЦБ үйлдвэрлэх журам, бүтээгдэхүүн тус бүрийн САЗ, ТТАЗ, АЗ боловсруулж, батлуулан мөрддөг 2. ЦЦБ үйлдвэрлэсэн протоколийг бүтээгдэхүүн тус бүрээр бүрэн хөтөлж баримтжуулсан 3. Үйлдвэрлэсэн ЦЦБ бүрээс чанарын хяналтын шинжилгээнд бүрэн хамруулж, үр дүнг баримтжуулсан 4. ЦЦБ-ийг халдвар илрүүлэх, бүлэг тодорхойлох шинжилгээнд бүрэн хамруулж, баримтжуулсан 5. ЦЦБ-ийг хорионд хадгалах, шалгуур үзүүлэлтийн дагуу хорионоос чөлөөлсөн баримтжуулалтыг бүрэн хөтөлсөн 	5, 4, 3, 2, 0
	2.3.Эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээг хангах ЦЦБ үйлдвэрлэхэд хүрэлцэхүйц цусны донортой, донорын бүртгэлийн тогтолцоог бүрдүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Донорын эгнээг өргөжүүлэх, хадгалах, сургалт, сурталчилгаа хийх төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, үр дүнг тооцдог 2. Цусны донорын бүртгэлийн тогтолцоог бүрдүүлсэн. Цусны донорын төрөл, нас, хүйс, цусны бүлгээр ангилсан судалгаа, бүртгэлтэй 3. Цус, сийвэн цуглуулах төлөвлөгөө боловсруулж, мөрддөг, хэрэгжилтэнд хяналт тавьдаг 4. Цусны донорыг сонгох шалгуур үзүүлэлттэй, үзүүлэлтийн дагуу сонгож, баримтжуулсан 5. Донорт эрүүл мэнд, эрүүл аж төрөх ёсны талаар мэдээлэл, зөвлөгөө өгч баримтжуулсан 	5, 4, 3, 2, 0
	2.4.Донорт үйлчлэх тухтай орчинг бүрдүүлсэн, донорын нууцлалыг хадгалсан байх	<ol style="list-style-type: none"> 1. Донор тав тухтай орчинд, аюулгүй үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн 2. Донорын үүрэг, эрх, хариуцлага, шалгуур үзүүлэлт, эрүүл мэндийн асуумж бөглөх мэдээллээр хангадаг 3. Донорын нууцлалыг хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн 4. Донортой ганцаарчилсан ярилцлага, эрүүл мэндийн үзлэг хийх боломжтой 	5, 4, 3, 2, 0
	2.5.Цусны донор, цуглуулсан цусны нэгж бүрийг бүрэн, зөв шинжлэх тогтолцоог бүрдүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. Донорт цус, сийвэн эс өгөхийн өмнө хийгдэх шинжилгээг бүрэн хийж, баримтжуулдаг 2. Цуглуулсан цус, сийвэн, эс бүрд цус сэлбэлтээр дамждаг 4 үндсэн халдвар илрүүлэх болон АВО, резус, Келл бүлэг тодорхойлох шинжилгээг бүрэн хийж баримтжуулдаг 	5, 4, 3, 2, 0

			<ul style="list-style-type: none"> 3. Шинжилгээнд стратеги, алгоритм мөрдөж, баримтжуулсан 4. Шинжилгээнд дотоод хяналтыг тогтмол хийж баримтжуулдаг 5. Шинжилгээ тус бүрээр чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт хамрагдаж, үр дүнг баримтжуулсан 6. ЦЦБ-д чанарын хяналтын шинжилгээг бүрэн хийж үр дүн нь шаардлагад бүрэн нийцсэн 7. Иммуногематологийн лавлагаа шинжилгээ хийсэн бүртгэл, үр дүнг тооцсон 	
		2.6.ЦЦБ-ний хадгалалт, тээвэрлэх хүйтэн хэлхээний тогтолцоог бүрдүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> 1. ЦЦБ хадгалах зориулалтын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжөөр хангасан байдал, хувь 2. ЦЦБ-ний хадгалалт, тээвэрлэлтийн журам мөрддөг 3. ЦЦБ хадгалалт тээвэрлэлтийн хэмийг байнга хянаж, баримтжуулсан 4. Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн хэмийг зөв байдлыг баталгаажуулж, шалган тохируулсан 	5, 4, 3, 2, 0
3.	Эмнэлгийн мэргэжилтний мэргэшил, ур чадварыг дээшлүүлж, ажлын гүйцэтгэлийг үнэлдэг байна.	3.1.Тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэшсэн/ сургагдсан, ур чадвартай байх	<ul style="list-style-type: none"> 1. Байгууллагын мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандартад заасан орон тооны хангалтын хувь 2. Эмнэлгийн мэргэжилтнүүд хүчинтэй хугацаа бүхий мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 3. Эмнэлгийн мэргэжилтнүүд ажлын байранд тавигдах шаардлагад тохирсон мэргэшсэн/ сургасан 4. Эмнэлгийн мэргэжилтнүүд ур чадвар эзэмшсэн, ур чадварыг үнэлдэг журамтай 	5, 4, 3, 2, 0
		3.2.Эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтад хамруулж, ур чадварыг дээшлүүлдэг байх	<ul style="list-style-type: none"> 1. Тасралтгүй сургалтын хөтөлбөртэй 2. Сургалтанд хамрагдсан бүртгэлтэй, хамрагдалтын хувь 3. Эмч, мэргэжилтний багц цагийн бүрдүүлэлт 4. Эмч, мэргэжилтнүүдийн ур чадварын үнэлгээтэй 	5, 4, 3, 2, 0
		3.3.Шинэ ажилтанг чиглүүлэх, дадлагажуулах сургалтад хамруулсан, дэмжлэг үзүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> 1. Чиглүүлэх, дадлагажуулах сургалтын хөтөлбөртэй 2. Шинэ ажилтны хамрагдалтын хувь 3. Сургалт хийсэн, үр дүнг дүгнэсэн 4. Тайлан, баримтжуулалт хийсэн 	5, 4, 3, 2, 0
		3.4.Эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийж, дүгнэлт өгдөг байх	<ul style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийг үнэлэх батлагдсан журам, шалгуур, үзүүлэлттэй 2. Ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийдэг 	5, 4, 3, 2, 0

			<ul style="list-style-type: none"> 3. Үнэлгээг ажилтанд танилцуулж баталгаажуулсан 4. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тайлантай 5. Гүйцэтгэлийг үндэслэн урамшуулдаг 	
4.	Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулдаг байна.	<p>4.1.Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг байнга сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байх</p>	<ul style="list-style-type: none"> 1. Байгууллага, тасаг, нэгж нь тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийж баримтжуулдаг 2. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөдөг, үр дүнг үнэлдэг 3. Ажилтан бүрийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт чанар сайжруулах үйл ажиллагааны оролцоог тусгасан 4. Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, баримттай 5. Байгууллагын хэмжээнд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагаанд манлайлан зохион байгуулсан болон хамтарч оролцсон байдал 	5, 4, 3, 2, 0
		<p>4.2.Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үзүүлэлтэд дүн шинжилгээ тогтмол хийж, сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлдэг байх</p>	<ul style="list-style-type: none"> 1. Цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг баталсан 2. Шалгуур үзүүлэлтүүдэд хэмжилт, дүн шинжилгээ тогтмол хийдэг, тайлан, дүгнэлттэй 3. Шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах, шинэчлэх ажлыг хийсэн, үр дүнг тооцдог 	5, 4, 3, 2, 0

5.	Тусламж, үйлчилгээний технологийг мөрдөж, аюулгүй байдлыг хангасан байна.	5.1.Цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээний технологийг мөрдөх нөхцөл бүрдүүлж, хэрэгжүүлдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. Өөрийн байгууллагад хийгдэх оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, үйл ажиллагааны жагсаалтыг баталсан 2. Оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, үйл ажиллагааны стандарт, удирдамж, зааврыг батлуулсан, эмнэлгийн мэргэжилтнүүд ашиглах нөхцөл бүрдсэн 3. Оношилгоо, эмчилгээ, эмчилгээ, үйл ажиллагааны стандарт, удирдамж, зааврын мөрдөлтөд хяналт тавьдаг, 4. Сайжруулах, шинэчлэх арга хэмжээ авдаг 5. Цусны аюулгүй байдал, ЦЦБ–ний зохистой хэрэглээг хэвшүүлэх чигэлээр хэрэгцээнд тулгаарласан сургалт зохион байгуулдаг 6. Эрүүл мэндийн байгууллага, эмч нарт зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйгээр хангадаг 	5, 4, 3, 2, 0
6.	Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг үзүүлж, Цусны аюулгүй байдлыг хангаж, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх зөв дадал хэвшүүлж ажиллана.	6.1.ЦЦБ-ийг зохистой хэрэглэх тогтолцоог бүрдүүлсэн байх	<ol style="list-style-type: none"> 1. ЦЦБ-ийг зохистой хэрэглэх үндэсний болон байгууллагын зааврыг мөрддөг 2. Эмч, мэргэжилтнүүд дээрхи зааврыг ашиглах боломж бүрдүүлсэн 3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах ЦЦБ-ний хэрэглээг хэрэгцээг судалж, тогтоосон 4. Эмнэлгийн үйл ажиллагаанд шаардагдах ЦЦБ-ний нөөцийн хэмжээг тогтоосон, нөхөн хангалт хийдэг 	5, 4, 3, 2, 0
		6.2.ЦЦБ сэлбэх заалтыг зөв гарган оновчтой сонголт хийн захиалга хийдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. ЦЦБ сэлбэх эмнэлзүйн болон лабораторийн заалтыг гаргаж, өвчний түүхэнд тэмдэглэсэн, 2. Үйлчлүүлэгчид ЦЦБ сэлбэх заалт, үр дүн, гарч болох урвал, хүндрэлийн талаар танилцуулж, ЦЦБ сэлбүүлэх зөвшөөрлийг авч баталгаажуулан өвчний түүхэнд хавсаргасан 3. ЦЦБ сэлбэх өвчтөнийн танин тодруулах зааврыг мөрддөг 4. Танин тодруулсан тухай хянаж, баримтжуулдаг 5. Цусны АВО бүлэг, резус бүлэг тодорхойлж өвчний түүхэнд баримтжуулдаг 6. Цусны бүлэг баталгаажуулах, хувийн тохироо тодорхойлох шинжилгээний сорьц авч баримтжуулдаг 7. Сорьцыг зөв авч, зөв хаягласан хяналтын хуудас 	5, 4, 3, 2, 0

			<p>ашигладаг</p> <p>8. Захиалгыг хийн баримтжуулдаг</p>	
	6.3.Сэлбэх ЦЦБ-ийг зөв сонгох, цус сэлбэхийн өмнө хийх шинжилгээг бүрэн хийх	<ol style="list-style-type: none"> 1. ЦЦБ сэлбэхийн өмнө шинжилгээ хийх журмыг баталсан, мөрддөг 2. Эмнэлгийн лаборатори цус сэлбэхийн өмнө хийх шинжилгээг бүрэн, зөв хийх нөхцөл бүрдүүлсэн 3. Шинжилгээнд хэрэглэх тоног төхөөрөмжийн баталгаажуулалт, тохиргоо, арчилгаа, үйлчилгээ хийсэн баримтжуулалт хөтөлдөг 4. Шинжилгээнд хэрэглэх оношлуурын чанарын баталгааг хагаж баримтжуулдаг 5. Эмч мэргэжилтнүүдийг цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох шинжигээ хийх аргад сургаж, ур чадвар эзэмшүүлсэн 6. Сийвэнгийн бүтээгдэхүүн, ялтас эсийн бүтээгдэхүүний хийх өвчтөний цусны ABO, резус бүлэг баталгаажуулах шинжилгээг бүрэн хийж, баримтжуулдаг 7. Улаан эсийн бүтээгдэхүүн хийх өвчтөнд сэлбэх нэгж бүрт хувийн тохироо тодорхойлох шинжилгээг бүрэн хийж баримтжуулдаг 8. Ердийн болон сэрэмжлүүлэх шинжилгээний хариуг олгосон бүртгэл хөтөлдөг 9. Шинжилгээ бүрт дотоод хяналтыг тогтмол хийж баримтжуулдаг 10. Цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох шинжилгээний Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт бүрэн хамрагдаж, үр дүнг тооцдог 11. Сорьц хадгалж, устгасан баримтжуулалт хөтөлдөг 	5, 4, 3, 2, 0	
	6.4.ЦЦБ-ийг зөв, аюулгүй сэлбэдэг байх	<ol style="list-style-type: none"> 1. ЦЦБ сэлбэх заалт гарган бүлэг, хувийн тохироо тодорхойлох шинжилгээний сорьц авсан өвчтөнийг зөв танин тодруулж, баримтжуулдаг 2. Сэлбэх ЦЦБ-ний чанарыг хянаж, шалгадаг 3. Бүлэг хувийн тохироо тохирсон зөв бүтээгдэхүүн болохыг танин тодруулж, хянаж, баримтжуулдаг 	5, 4, 3, 2, 0	

			<ul style="list-style-type: none"> 4. ЦЦБ сэлбэх өвчтөний бэлтгэлийг хянаж, баримтжуулдаг 5. ЦЦБ-ийг зориулалтын сэлбэх системээр сэлбэдэг 6. Биологийн тохироо тодорхойлдог 7. ЦЦБ сэлбэлтийн явцыг бүрэн хянаж, баримтжуулдаг 8. Эмчилгээний үр дүнг үнэлж, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр баримтжуулдаг 	
		6.5.Цусны аюулгүй байдлыг хангах хяналт, үнэлгээний тогтолцоог бүрдүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> 1. Цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээний тогтолцоог хэрэгжүүлэх журамтай, мөрддөг 2. Эмч, мэргэжилтнүүд сургагдсан, ашиглах боломжтой 3. ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийг оношилж, бүртгэж, мэдээлдэг, маягт хөтөлдөг 4. ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэл илэрсэн үед шуурхай авах арга хэмжээ зүйлсээр хангагдсан 5. ЦЦБ сэлбэсэнтэй холбоотой урвал, хүндрэлийн шалтгааныг тогтоож, засах, сэргийлэх арга хэмжээг хэрэглүүлж, баримтжуулдаг 	5, 4, 3, 2, 0
7.	ЦЦБ хадгалалт, олголт, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.	7.1.Эмнэлэг, тасаг, нэгжид захиалгын маягтын дагуу ЦЦБ-ийг олгож, баримтжуулсан байх	<ul style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн тасаг, нэгжид захиалгын маягтын дагуу, цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох шинжилгээний хариуны дагуу сонгосон ЦЦБ-ийг олгож, баримтжуулдаг 2. Эмнэлгийн, тасаг, нэгжид ЦЦБ захиалсан, нөөцөнд хадгалсан, эмчилгээнд олгосон, хүлээн авсан, сэлбэсэн, устгасан, бүртгэл, анхан шатны маягтыг хөтөлдөг 3. ЦЦБ сэлбэх үйл ажиллагаанд оролцдог эмч, мэргэжилтнүүдийг ЦЦБ-ийг хадгалах, зөв тээвэрлэх, зөв харьцах, сэлбэх талаар мэргэжил арга зүйгээр хангаж ажилладаг 	5, 4, 3, 2, 0
		7.2.ЦЦБ-ийг хүйтэн хэлхээний горимт зөв хадаглах, тээвэрлэх нөхцөл бүрдүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> 1. ЦЦБ-ийг зориулалтын хөргөгч, хөлдөөгчинд хадгалдаг 2. Хадгалалтын хэмийг тогтмол хянаж, бүртгэдэг 3. ЦЦБ-ыг зориулалтын хүйтэн хэлхээний саванд хийн тээвэрлэдэг 4. Тээвэрлэлтийн хэмийг тогтмол хянаж бүртгэдэг 5. Хадгалалт, тээвэрлэлт хариуцсан эмч, мэргэжилтнүүдийг сургаж, дадлагажуулсан 	5, 4, 3, 2, 0
Онооны дүн		Авбал зохих оноо	...	
		Авсан оноо	...	

Эрүүл мэндийн сайдын 2019 оны
12 сарын 06 - ны өдрийн
АСС дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД МАГАДЛАН ШИНЖЛЭХ
ШАЛГУУРААР ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ**

Нэг. Үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, магадлан шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэглэнэ.

Хоёр. Үнэлгээний зарчим, хамрах хүрээ

2.1. Магадлан шинжилгээ, үнэлгээнд дараах зарчмыг баримтлана:

- 2.1.1. шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх;
- 2.1.2. нээлттэй, ил тод байх;
- 2.1.3. нотолгоонд тулгуурласан байх;
- 2.1.4. үр дүнд чиглэсэн байх;
- 2.1.5. мэдээлэл нь үнэн, зөв байх;
- 2.1.6. оролцогч, хэрэглэгч талуудын оролцоог хангасан байх;
- 2.1.7. багаар ажилласан байх;

2.2. Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн бүх эрүүл мэндийн байгууллага /төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, оношилгоо эмчилгээний болон хавсарсан клиник/-д магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтээр шинжээчийн баг үнэлгээ хийхэд болон магадлан итгэмжлэлд орох дээрх эрүүл мэндийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны гүйцэтгэл болон үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологийг үнэлэхэд энэхүү аргачлалыг ашиглана.

Гурав. Магадлан шинжлэх шалгуурын бүтэц, үнэлгээ хийх

3.1. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуур нь дараах бүтэцтэй:

- 3.1.1. Магадлан итгэмжлэлд орох байгууллагад тавигдах үндсэн шаардлага
- 3.1.2. Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд /Бүлэг 1/
- 3.1.3. Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд /Бүлэг 2/
- 3.1.4. Үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд /Бүлэг 3/

3.2. Эрүүл мэндийн байгууллага нь магадлан итгэмжлэх журам болон магадлан шинжлэх шалгуурын хүрээнд баталсан дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.2.1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд заагдсан тусламж, үйлчилгээний төрөл бүрээр үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийдэг;

3.2.2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд заасан ажлын байрны хаягандаа үйл ажиллагаа явуулдаг;

3.2.3. Стандартад заасан орон тоогоор эмнэлгийн мэргэжилтнийг хангасан, 80-аас дээш хувь нь сүүлийн 1 жилийн дотор тогтвор суурьшилтай ажиллаж байгаа;

3.2.4. Эмнэлгийн мэргэжилтнүүд нь мэргэшсэн, жил бүр ур чадварыг дээшлүүлдэг тогтолцоо бүрдсэн;

3.2.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан зориулалтын байртай, үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдүүлсэн;

3.2.6. Жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг байх, улирлын үйл ажиллагаатай сувилал нь жилдээ 6 сараас доошгүй хугацаанд ажилладаг;

3.2.7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, өвчтөний аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагаанд хамт олны оролцоог хангаж ажилладаг;

3.2.8. Магадлан итгэмжлэлд орох асуудлыг хамт олноороо хэлэлцэж, хүлээн зөвшөөрсөн;

3.2.9. Магадлан итгэмжлэлд бэлтгэх зөвлөгөө авч, сургалтанд хамрагдсан;

3.2.10. Магадлан шинжлэх шалгуураар хийсэн өөрийн үнэлгээгээр шалгуур үзүүлэлтийг 100% хангасан;

3.2.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлж, ахиц өөрчлөлт гарсан;

3.2.12. Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг баталсан, тогтмол хэмждэг, жил бүр ахиц өөрчлөлт гарсан;

3.2.13. Байгууллагын эрсдлийг үнэлж, сэргийлэх, бууруулах хариу арга хэмжээ тогтмол авдаг байх;

3.3. Шинжээчийн багийн эрүүл мэндийн байгууллага дээр очиж хийсэн үнэлгээгээр 3.2-т заасан үндсэн шаардлагыг хангаагүй бол магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийхгүй бөгөөд тухайн эрүүл мэндийн байгууллагыг шалгуур үзүүлэлтийг хангаагүй гэж дүгнэнэ.

3.4.Шалгуур үзүүлэлтийн бүлэг тус бүр дараах дэд бүлгүүдтэй.

Бүлэг	Дэд бүлэг	Шалгуур үзүүлэлтийн хамаарал
Бүлэг 1. Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд	1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах	Бүх эрүүл мэндийн байгууллагыг үнэлнэ.
	2.Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал	
	3. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах	
	4. Үзлэг, оношилгоо, эмчилгээ	
	5. Халдварын сэргийлэлт, хяналт	
	6. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	
Бүлэг 2. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуурүзүүлэлтүүд	1. Эрүүл мэндийн байгууллагын засаглал, удирдлага, манлайлал	Бүх эрүүл мэндийн байгууллагыг үнэлнэ.
	2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлага	
	3. Хүний нөөцийн хөгжил	
	4. Мэдээллийн удирдлага, аюулгүй байдал	
	5. Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ	
	6. Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа	
Бүлэг 3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд	1. Амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээ	Бүх эрүүл мэндийн байгууллагыг үнэлнэ.
	2. Сувилахуйн тусламж, үйлчилгээ	
	3. Эмийн менежмент ба зохистой хэрэглээ	
	4. Лабораторийн тусламж, үйлчилгээ	
	5. Эмчилгээний хоол	
	6. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээ	
	7. Мэдээгүйжүүлэг, мэс заслын тусламж, үйлчилгээ	Тухайн байгууллагын тусгай зөвшөөрөл эрхлэх үйл ажиллагааны чиглэлд заасан тусламж,
	8. Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээ	
	9. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	
	10.Дотрын тусламж, үйлчилгээ	
	11.Мэдрэлийн тусламж, үйлчилгээ	

12. Хүүхдийн тусламж, үйлчилгээ	үйлчилгээний төрлөөр сонгож үнэлнэ.
13. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	
14. Хавдрын тусламж, үйлчилгээ	
15. Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ	
16. Халдварт өвчний тусламж, үйлчилгээ	
17. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	
18. Нүдний тусламж, үйлчилгээ	
19. Нүүр амны тусламж, үйлчилгээ	
20. Чих хамар, хоолойн тусламж, үйлчилгээ	
21. Дүрс оношилгоо	
22. Сэргээн засах тусламж, үйлчилгээ	
23. Цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээ	

3.3. Дэд бүлэг бүр эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих үзүүлэлтгэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

3.3.1. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага нь тухайн эрүүл мэндийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлсэн байх ёстой үндсэн үйл ажиллагаа юм.

3.3.2. Шалгуур үзүүлэлт нь тухайн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлно.

3.3.3. Хэмжих үзүүлэлт нь тухайн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан эсэхийг нотлох, оноо өгөх үндэслэл болох баримтыг хэлнэ.

3.4. Шалгуур үзүүлэлт бүрийг **5, 4, 3, 2, 0** гэсэн оноогоор дүгнэнэ.

5 оноо – тухайн шалгуур үзүүлэлтийг хэмжих үзүүлэлтийг 100 хувь хангасан буюу үйл ажиллагааны зохицуулалтыг /тушаал, дүрэм, журамтай/ бүрэн хийсэн, хэрэгждэг, тухайн үйл ажиллагаа хэвшсэн, тогтмол үнэлж дүгнэдэг, бодит үр дүн гарсан бол;

4 оноо – тухайн шалгуур үзүүлэлтийг хэмжих үзүүлэлтийн 90-ээс дээш хувийг хангасан буюу үйл ажиллагааны зохицуулалтыг /тушаал, дүрэм, журамтай/ хийсэн, хэрэгждэг, тухайн үйл ажиллагаа хэвшээгүй, заримдаа үнэлж дүгнэдэг, үр дүн тогтвортой биш бол;

3 оноо – тухайн шалгуур үзүүлэлтийг хэмжих үзүүлэлтийн 80-аас дээш хувийг хангасан буюу үйл ажиллагааны зохицуулалт /тушаал, дүрэм, журамтай/

хийгдсэн боловч хэрэгждэггүй, үйл ажиллагаа бүрэн хэрэгжээгүй, үр дүн гарч эхэлж байгаа бол;

2 оноо - тухайн шалгуур үзүүлэлтийг хэмжих үзүүлэлтийн 70-аас дээш хувийг хангасан буюу үйл ажиллагааны зохицуулалт /тушаал, дүрэм, журам/ шаардлага хангахгүй, үйл ажиллагаа эхлэл төдий, үр дүнгүй бол;

0 оноо - огт хийгдээгүй;

3.5. Хувиар илэрхийлэгдэх шалгуур үзүүлэлтийг үнэлэхдээ 100% хангасан бол 5 оноо, 99- 90%-д 4 оноо, 89-80%-д 3 оноо, 79-70%-д 2 оноо, 69 ба түүнээс доош хувьд 0 оноог тус тус өгнө.

3.6. Шалгуур үзүүлэлт бүрийн нийлбэр оноогоор тухайн дэд бүлгийн, дэд бүлэг бүрийн нийлбэр оноогоор бүлгийн, бүлэг бүрийн онооны нийлбэрээр онооны нийт дүн гарна.

3.7. Нийт авсан онооны нийлбэрийг авбал зохих оноонд харгалзуулан тухайн онооны эзлэх хувийг тооцон нэгдсэн дүнг гаргана. Эрүүл мэндийн байгууллагын магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийг хангасан хувийг үндэслэн магадлан итгэмжлэл олгох эсэх асуудлыг эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журмаар зохицуулна.

3.8. Эрүүл мэндийн байгууллага нь магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтээр өөрийн үйл ажиллагаа болон үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологит үнэлгээ хийхдээ байгууллагын ажилтнуудын бүх түвшний төлөөллийг оролцуулан багаар ажиллана.

3.9. Шинжээчийн баг нь эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийхдээ тасаг, нэгж бүрээр тойрон үзлэг хийх, баримт бичигтэй танилцах, мэдээлэл солилцох, эмнэлгийн мэргэжилтний гардан үйлдэл хийх явцад ажиглалт хийх, удирдах болон эмнэлгийн ажилтан, үйлчлүүлэгчтэй ярилцлага хийх зэрэг аргуудыг ашиглана.

Дөрөв.Үнэлгээний үр дүнг тооцох

4.1. Шинжээчийн багийн эрүүл мэндийн байгууллагад хийсэн магадлан итгэмжлэлийн үнэлгээний тайлан, дүгнэлт бичих, үнэлгээний үр дүнг шийдвэрлэх асуудал нь “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам” болон магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой бусад журмуудаар зохицуулагдана.